

Аймгийн засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн ХШҮ-ний тайлан

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

2023 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
1	1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны	1. Коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах	2021 - 2024		100	Аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах чиглэлээр албадын бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.	100%
2	халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны	2. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлтгэл, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах	2021 - 2024		95	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 тогтоолын хавсралтаар батлагдсан 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны “Заавар батлах тухай” А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бэлэн байдлын үзлэг зохион байгуулах заавар”-ыг удирдлага болгон Баянцагаан суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2023 оны 04 дүгээр	100%

	бэлэн байдлыг хангана.					сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулж, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн нийт 80 орчим ажилтан, албан хаагч оролцож гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг ойлголтоо дээшлүүлсэн бөгөөд тус суманд ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс 90,1 хувь "А", "Дүүрэн хангалттай" үнэлгээг өгсөн болно.	
3	1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлнэ.	1. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх	2021 - 2024		95	"Ковид-19" вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг Шадар сайдын 28 дугаар тушаалын дагуу ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Онцгой байдлын газар болон бусад байгууллагатай хамтран хийх боломж бүрдсэн. 2023 оны хагас жилийн нөхцөл байдлын хувьд өдөрт гарах ковидын шинэ хувилбар 20 дотор илэрч байгаа учир эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй байна. Ковидын нөхцөл байдлын талаар цахим мэдээллийн сувгаар болон холбогдох байгууллага, газруудад мэдээ мэдээлэл, танилцуулга хүргүүлэн уялдаа холбоог ханган ажиллаж байна.	100%
4	1.1.3. Иргэдэд корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна.	1. Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг	2021 - 2024		90	Иргэдийг "Ковид-19" халдвараас сэргийлэх сургалт мэдээллийг хуваарьт өдрүүдэд цахимаар болон танхимын хэлбэрээр зохион байгуулж нийт 30 удаагийн сургалтаар 10860 иргэн хамрагдсан байна. Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хагас жилийн байдлаар хэрэгжилт 70 хувьтай байна.	100%

		хангах					
5	1.1.4. “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. “Ковид-19” вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцох	2021 - 2024		"Бага"	Улс, аймгийн хэмжээнд Ковид-19-ын халдварын тархалт 2021 эрсдэлийн үнэлгээ хийж "Өндөр эрсдэлтэй" байсан. 2022 оноос халдварын тархалт зогсож, ногоон түвшинд шилжсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын шийдвэрээр салбар дундын эрсдэлийн үнэлгээг хийх шаардлагагүй гэж шийдвэрлэсний дагуу эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй болно. 2023 оны хагас жилийн нөхцөл байдлын хувьд өдөрт гарах ковидын шинэ хувилбар 20 дотор илэрч байгаа учир эрсдэлийн үнэлгээ хийх боломжгүй байна. Ковидын мэдээллийг өдөр тутам мэдээллийн сувгаар болон холбогдох газруудад танилцуулан ажиллаж байна.	100%
6	үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх	2021 - 2024		90	Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах зорилгоор “Төв штаб”-ын бүтцийг шуурхай бүлгийн бүтэц бүрэлдэхүүнд шилжүүлж, албадын бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.	100%
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ							
7	2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник	1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021 - 2024		90	Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар Улсын төсвийн 312.0 сая төгрөг төсөвт тусгагдсанаас нэгжийн үнэ 15.0 сая, нийт үнэ 180.0 сая төгрөгний өртөгтэй гематлогийн анализаторыг 12 сум, өрхийн эрүүл мэндийн төвд нийлүүлсэн. Тус онд үлдэгдэл санхүүжилт болох 132.0 сая төгрөгний биохимийн бүрэн автомат 6 ширхэг анализаторыг 2023 оны 07 дугаар сард нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Рейсинг мед”	90%

	технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.					ХХК-тай хамтран ажиллаж байна. Сумдын Эрүүл мэндийн төвүүдийг лабораторын тоног төхөөрөмжөөр хангаснаар үр дүнд нь алсагдсан хүн амд оношлогоо, шинжилгээ хийх боломж нөхцөл бүрдсэн.	
8	2. Уламжлалт-сэргээн засах төвийг шинээр зохион байгуулан, шаардлагатай багаж хэрэгслээр ханган, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	2021 - 2024		3000	2023 оны эхний 5 сарын байдлаар Уламжлалт эмчилгээний тасагт-227, Өдрийн эмчилгээнд -43 Амбулаториор 1219 хүн тус тус үйлчлүүлсэн байна. Уламжлалт, сэргээн засах эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэвтрүүлэх зорилгоор нийт 139,600,000 төгрөгний тендер зарлаж, уламжлалт, эмийн бус эмчилгээний болон хөдөлгөөн засал эмчилгээний нийт 27 нэр төрлийн багаж тоног төхөөрөмж нэмэгдүүлж ажилласан байна. Үүнд: - Улаан туяа эмчилгээг давхардсан тоогоор 130, - Цахилгаан гүйдэл эмчилгээ-УВЧ-370 - Искра-135 - Цахилгаан бумба эмчилгээ-290 - Лазер эмчилгээ-75 - Цахилгаан зүү-350 - Хаш чулуун ор-50 - Татлага эмчилгээ-25 - Шавар эмчилгээ-1009 хүнд тус тус хамрагдсан байна. Шинээр хөдөлгөөн засалчийг орон тоогоор ажиллуулж, 264 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан байна.	50%	
9	3. Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, зүрхний шигдээсийн үеийн эмчилгээг хийж хэвшүүлэх	2021 - 2024		16.1	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт энэ оны эхний 5 сарын байдлаар Зүрхний цочмог болон архаг ишеми өвчний шалтгаант 13 өвчлөл бүртгэгдсэн байна. Үүнээс 5 хүн шинээр ишеми өвчин оношилогдож, цаг алдалгүй төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, оношийн зөрүү бүртгэгдээгүй байна.	30%	
10	4. Уушигны дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн, тусламж	2021 - 2024		3.9	Нэгдсэн эмнэлэгт уушигны нарийн мэргэжлийн 1 их эмч бэлтгэгдсэн хүний нөөцийг хангасан. Цаашид дурангийн чиглэлээр сургахаар саналаа эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Нэгдсэн эмнэлэг 139.0 сая төгрөгний төсөвт өртөгтэй уушигны дурангийн багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан.	30%	

		үйлчилгээнд нэвтрүүлэх					
11		5. Вирус судлалын лабораторийг шинээр нээх	2022 - 2024		15	2023 оны эхний 5 сарын байдлаар Вирус судлалын лабораторит 347 сорьцын шинжилгээ хийгдсэн. Үүнээс: SARS-19 болон томуугийн АВ хүрээний 86 вирус тодорхойлох шинжилгээнээс 42 (48,8%) эерэг бүртгэгдсэн. ХӨСҮТ-д илгээсэн шинжилгээнд 100 хувь тохиргоо таарч баталгаажуулалт хийгдсэн. Мөн шинжилгээний гадаад хяналтыг 2 удаа (ХӨСҮТ болон олон улсын) хийлгэн “Хангалттай” үнэлгээ авч, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийх эрхээ авсан.	100%
12		6. Элэгний В вирустай эхчүүдээс төрсөн нярай бүрт Гепабиг эмчилгээг нэвтрүүлэх	2021 - 2024		150	Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар сумын Эрүүл мэндийн төвд В вирустэй эх төрөөгүй. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасагт 28 эх төрснөөс нярайд 100 хувь иммуноглобулин G эмчилгээ бүрэн хийгдсэн.	100%
13	2.1.2. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн	1. Цэргийн насны 18-25 насны эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх	2021 - 2024		200	Цэрэг татлагын 2023 оны 1-р ээлжид 10 сум, 3 өрхийн Эрүүл мэндийн төвийн харьяа 17-25 насны нийт 974 залуу цэргийн жинхэнэ албаны комиссоор орж, эмчийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан. Нийт үзлэгээр орсон залуучуудын 338 буюу 54,5% хувь нь эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн жинхэнэ албанд тэнцээгүй. Бүртгэгдсэн өвчлөлийг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллэж, эрүүлжүүлэх төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100%
14		2. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	2022 - 2024		400	Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулах ажил Нэгдсэн эмнэлгийн засварын ажилтай холбоотойгоор хойшлогдож, одоогоор Мэс заслын кабинетэд үйл ажиллагаа явуулж байна. Эхний 5 сарын байдлаар 2 тохиолдолд урологийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Хүний нөөцийн хувьд эмч, сувилагчийг бэлтгэсэн цаашид эрэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлэхээр ажиллаж байна.	30%

15	үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эрхүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	2022 - 2024		90	"Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 9 ажил зохион байгуулахаар тусган 51.1 хувьтай хэрэгжүүлсэн. Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү багасгах зорилтын хүрээнд: /Аймгийн дундаж 71.28 Үүнээс Эрэгтэй 68.17 Эмэгтэй 73.21 байгаа нь улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна/ Аймгийн хэмжээнд 5 сарын байдлаар Нэгдсэн эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн 8 Эрүүл мэндийн байгууллагаар 104821 үзлэг хийгдсэнээс 22043 урьдчилан сэргийлэх үзлэг /эрэгтэйчүүд 10158/ хийгдсэн байна. Мөн эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоонд нийт 30216 хүн хамрагдан үүнээс 13245 буюу 43,8 хувийг эрэгтэйчүүд эзлэж байна. Эрүүл мэндийн лавлагаа, болон анхан шатны байгууллагаар иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Нийт 12484 иргэний 5126 буюу 41 хувь нь эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт мэдээллийг өгч ажилласан.	50%
16	2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	1. Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах	2021 - 2024		70	Нэгдсэн эмнэлгийн БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет 3 их эмч, 2 сувилагч, 1 сайн дурын зөвлөгөө шинжилгээний зөвлөгч, 2 лаборанттай үйл ажиллагаагаа явуулж байна. 2023 оны 05 сарын байдлаар тэмбүү-37, заг хүйтэн-54, трихоминиаз-91 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүү-30, заг хүйтэн-51, трихоминиаз-79 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Эхний 5 сарын байдлаар нийт 1428 жирэмсэн эх БЗДХ-ын шинжилгээнд хамрагдаж үүнээс тэмбүү-13, трихоминиаз-32 тохиолдол бүртгэгдэж заг хүйтэн өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. Албан байгууллагуудын 24 эрүүл мэндийн ажилтнуудад сүрьеэ болон БЗДХ-ын чиглэлээр сургалт орж, мэдлэгийн түвшин 7-14 хувиар нэмэгдсэн байна.	70%
17		2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг	2021 - 2024		3.5	Аймгийн хэмжээнд эхний 5 сарын байдлаар сүрьеэгийн 11 тохиолдол бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдлоор нэмэгдсэн. Эхний 5 сарын байдлаар сумаас аймгийн сүрьеэгийн диспансерт нийт 20 сумаас 366	70%

		зохион байгуулах				сорьцийг тээвэрлэснээс 2 хүний 4 сорьц түрхэц эерэг гарч эмчилгээнд хамруулсан. Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос 7.524.000 төгрөгний санхүүжилттэй 8 уурхайн 746 ажилчдад 06 дугаар сарын 06-ны өдрөөс сүрьеэ өвчний үзлэг шинжилгээг хийхээр төлөвлөн, Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/50 дугаар тушаалаар батлуулан бэлтгэл ажлыг хангасан.	
18		3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах	2022 - 2023		100	2023 оны эхний 5 сарын байдлаар нийт эрүүл мэндийн байгууллагуудад 104821 иргэнд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлснээс халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт 22043 буюу 21,0 хувь, Эрт илрүүлэг үзлэгт 30235 буюу 28.8 хувь хамрагдсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0,7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. /2022 оны 20,3 хувь/ Цаашид эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх 2 сарын аяныг салбарын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.	30%
19		4. Иргэдийг ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах	2022 - 2023		2000	Ковидын өвчлөлөөр 2021 онд нийт 25570, 2020 онд 7240, 2023 онд 141 хүн өвчлөөд байна. Үүнээс нэгдсэн эмнэлгийн сэргээн засах тасагт ковидын дараах хүндрэлээр 56 иргэн эмчүүлсэн байна.	100%
20	2.1.4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	2022 - 2024		200	Эхний 5 сарын байдлаар 489 нярай хүүхдэд түнхний ЭХО үзсэн. Хэвийн 405, В хэлбэр 81, С хэлбэр 6, D хэлбэр бүртгэгдээгүй байна. Нярайн сонсголыг 484 хүүхдэд хийснээс анхны үзлэгээс 2 талд тэнцээгүй 10 хүүхэд байснаас давтан үзлэгээр 17 нярайг үзэж, илрүүлэг үзлэг хэвийн явагдаж байна. Нярайн зүрхний гажгийн эрт илрүүлэг хийгдэхгүй байна. Тоног төхөөрөмжийн хангалт муу, бэлтгэгдсэн эмч шилжсэн байна.	0%
21		2. Нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх, скрининг	2021 - 2024		1500	Эхний 5 сарын байдлаар 489 нярай хүүхдэд түнхний ЭХО үзсэн. Хэвийн 405, В хэлбэр 81, С хэлбэр 6, D хэлбэр бүртгэгдээгүй байна. Нярайн сонсголыг 484 хүүхдэд анхны үзлэгээс 2 талд	50%

		болон сонсголын гажиг илрүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх				тэнцээгүй 10 хүүхэд байснаас давтан 17 нярай үзэж илрүүлэг үзлэг хэвийн явагдаж байна. Нярайн зүрхний гажгийн эрт илрүүлэг үзэхгүй байна. Багаж тоног төхөөрөмж байхгүй, бэлтгэгдсэн эмч шилжсэн.	
22	2.1.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана.	1. Иргэдийн хүлээгдэл чирэгдэлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	2021 - 2024		0	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар Эрүүл мэндийн байгууллагуудад 2604 түргэн тусламжийн дуудлага хүлээн авснаас 1167 алсын дуудлагад цаг хожимдолгүй үйлчилсэн байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг багасгах тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор цахим хуудас, дуудлага хүлээн авах, зөвлөгөө өгөх суурин утсыг 24 нэгжид тогтмол ажиллуулж байна. Аймгийн хэмжээнд амбулаторийн үзлэгийг 51676 иргэнд үзүүлж, Засгийн газрын 11-11 төвд иргэдээс тусламж үйлчилгээтэй холбоотой 5 гомдол санал бүртгэгдэж, уг гомдол саналыг бууруулахаар харьяа нэгжүүдэд чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна.	70%
23	2.1.6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Өвчтөний түүхийг цахимжуулж, E-Health програмыг бүрэн нэвтрүүлэх	2021 - 2024		90	Эмнэлгийн хэмжээнд тусламж үйлчилгээнд ашигладаг E-Health цахим програмыг бүрэн нэвтрүүлж, 14 тасаг нэгж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хэвтэн эмчлүүлэгчийн өвчний түүхийг цахим хэлбэрээр хөтөлж, цахим хувь үүсгэн хадгалдаг болсон. Ингэснээр тухайн өвчтний эрүүл мэндийн цахим дэвтэр үүсэх боломж бүрдсэн. Эрүүл Мэндийн Яам, Цахим Хөгжил, Харилцаа, Холбооны Яамнаас өгсөн чиглэлийн дагуу health.gov.mn, E-Health программаар 13А маягыг анхан шатнаас лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага хооронд цахимаар илгээх, хүлээн авах болон иргэд 13А маягт өөр дээр нь бичигдсэн эсэхээ төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аас харах нөхцөл бололцоог бүрдүүлсэн. Мөн E-Mongolia.mn-д эрүүл мэндийн холбогдолтой дараах үйлчилгээг авах боломж бүрдсэн. • Шинжилгээний хариу авах • Эмчийн үзлэгийн цаг захиалга • Эрт илрүүлэг үзлэгийн дүгнэлт • Эмнэлгийн магадлагаа • Цусны бүлгийн тодорхойлт • 13А маягт харах зэрэг 6 төрлийн үйлчилгээг цахимжуулсан. Эрүүл мэндийн “Цаг захиалгын нэгдсэн дуудлагын	100%

						төв”-д холбогдсоноор иргэд 1800-0119 дугаарт залган тухайн эмнэлгийн эмчийн үзлэгийн цаг авах боломж бүрдсэн. 2023 оны байдлаар гараар хөтлөгдөж байгаа 20 нэр төрлийн маягтуудыг цахим болгох үйл ажиллагаа хийгдээд явж байна.	
24		2. Олон улсын эмнэлзүйн удирдамж Upto date программыг нэвтрүүлэх	2021 - 2024		80	Нэгдсэн эмнэлгийн 73 их эмчийн 82 хувь нь UpTodate платформын ашиглаж байна. Сумын эрүүл мэндийн төвөөс 47 эмчийн 64 хувь нь, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн 14 эмчийн 57 хувь нь UpTodate платформыг тус тус ашиглаж байна. UpTodate платформын сургагч багшаар 2021 онд эрүүл мэндийн газраас 1, Нэгдсэн эмнэлгийн чанарын албаны дарга, чанарын менежер нар бэлтгэгдсэн, одоогоор ажиллаж байгаа 2 сургагч багш байна. Нэгдсэн эмнэлэг сум өрхийн Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 70 эмчид платформын хэрэглээ, кредит авч байгаа эсэхэд үнэлгээ хийж ажлын байранд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	70%
25	2.1.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	1. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр сургалтад хамруулах	2021 - 2024		900	2023-2024 оны хичээлийн жилд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн сургалтад 17, мэргэжил дээшлүүлэх сургаалтад 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн Улсын төсвийн санхүүжилтээр тус тус суралцаж байна. 2023 оны эхний 5 сарын байдлаар давхардсан тоогоор 117 чиглэлээр нийт 674 эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах ажлын байрны сургалтад хамрагдаж чадавхжсан байна.	100%
26		2. Иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, ёс зүйгээрээ бусдыгаа манлайлсан ажилтнуудыг урамшуулах, алдаршуулах	2021 - 2024		92	Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/55 дугаар тушаалаар "Бид ёс зүйгээр манлайлна" уриалгат аяныг 2023 оны 05 дугаар сарын 19-өөс 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж байна. Аяны хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сэтгэл ханамжийн судалгааг цахимаар авч байна.	30%

27		3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах	2021 - 2024		90	Салбарын хэмжээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтаар 61 эмнэлгийн мэргэжилтэд 293,4 мянган төгрөг, 29.2 дахь заалтаар 3 эмнэлгийн мэргэжилтэд 48,8 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон. 2023 оны хагас жилийн байдлаар салбарын хэмжээнд 331,5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. 2023-2024 оны хичээлийн жилд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн сургалтад 17, мэргэжил дээшлүүлэх сургаалтад 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр тус тус суралцаж байна. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хагас жилийн байдлаар нийт 310 эмч эмнэлгийн мэргэжилтэн 51,6 хувь хамрагдсан. Монгол улсын Төрийн одон медаль, эрүүл мэндийн яамны шагналд нэр дэвшүүлсэн 48 албан хаагч нарын материал, нэрсийн жагсаалтыг холбогдох газруудад хүргүүлж, 19 албан хаагч шагналаа гардаж авсан. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьтай байна.	70%
28	2.1.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга	1. Амбулаторийн барилгыг шинээр ашиглалтад оруулах	2021 - 2024		90	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын гүйцэтгэгчээр Рокпейнт групп шалгарч, 2023 оны улсын төсөвт 3868,6 сая төгрөг батлагдаж, өрлөгийн ажлыг эхлүүлэн, барилгын ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.	70%
29	байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай	2. Стандарт шаардлага хангасан хог хаягдлын байгууламжтай болох	2023 - 2024		50 0	Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны 12 дугаар сард стандартын шаардлага хангасан хог хаягдлын байгууламжийг ашиглалтад оруулсан. 2023 оны 05 дугаар сарын 18-нд хувийн хэвшлийн эмнэлэг, шүдний эмнэлгүүдэд албан бичиг хүргүүлэн, 39 байгууллагатай гэрээ хийсэн. Одоогийн байдлаар 4 өрхийн Эрүүл мэндийн төв /Наранмандал, Оточмандал, Оточномгон, Энхбүрд/, Ганзүү, Жаргалтай амьдрал төвтэй гэрээ хийж, эмнэлгийн хог хаягдлаас үүсэх халдварын эрсдлийг бууруулан ажиллаж байна.	70%
30	үйлчилгээг хүргэнэ.	3. Эмгэг судлалын барилгыг шинээр	2023		100	Эмгэг судлалын барилгын 375.4 сая төгрөгийн зураг төсөв хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS программд төсвийн хэрэгцээний мэдээлэл, зардал үр дүнгийн шинжилгээг	30%

		барих				бүрэн оруулж, 2024 оны Улсын төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлсэн.	
31	2.1.9. Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно.	1. Антибиотикийг жороор олгосон байдалд хяналт үнэлгээг хийж, хариуцлагатай тогтолцоог бий болгох	2021 - 2024		7000	Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 24 эмийн сангаас сар бүр жорын судалгаа авч, дүгнэлт гаргахад нийт 10 эрүүл мэндийн байгууллагаас 23899 ширхэг жор хүлээн авч, үүнээс эмчийн тамгагүй жор 15.0 хувь, өвчтөний нас хүйс бичээгүй 4.3 хувь, оношны код бичээгүй 4.1 хувь, антибиотик эмийг жоргүй олгосон 2.1 хувийг эзэлж байгаа зөрчил дутагдал байна. Зөрчил дутагдлыг арилгах ажлыг эрчимжүүлэн сургалт сурталчилгааг шат дараатай зохион байгуулан, мэргэжлийн байгууллагууд хяналт тавьж хамтран ажиллаж байна.	30%
32	ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно.	2. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх	2021 - 2024		89 15	Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор гаргасны дагуу аймаг, сумын эмийн сангууд нэгдсэн нэг үнээр хөнгөлөлттэй эмийг өгч, иргэдэд эм зүйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлж байна.	30%
33	2.2.1. Спорт цогцолбор бүхий усан бассейныг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах	2022 - 2024		50 500	Спорт цогцолбор бүхий усан бассейны иж бүрэн тоног төхөөрөмжийг Улс, орон нутгийн төсөв, Улсын их хурлын гишүүн Г.Занданшатарын дэмжлэг, хандив тусламжаар тохижуулан ажиллаж байна. Спорт цогцолбор бүхий усан бассейныг 2023 оны 2 сард ашиглалтад оруулсанаар хангайн бүсийн бүжгийн аварга, Мал эмнэлэг, Байгаль орчин аялал жуулчлын бүсийн аварга, Хангай бүсийн тогооч нарын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан ажилласан.	100%
34	2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг	1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж,	2022 - 2024		100	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Энэ жилдээ – эрүүл жиндээ”, “Цаг гаргая”, “Нарны алхалт” зэрэг аянуудыг Эрүүл мэндийн газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Ахмадын холбоо, сумдын биеийн тамирын арга зүйч, албан	100%

	хэрэгжүүлнэ.	хэрэгжүүлэх				байгууллага, аж ахуй нэгжүүдтэй хамтарч бүх нийтийн ажил арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Нийт давхардсан тоогоор 82 албан байгууллага, аж ахуй нэгжийн 37.000 хүн хамрагдсан. “Энэ жилдээ - Эрүүл жиндээ” аяны хүрээнд “Илүүдэл жин таргалалтыг тодорхойлох аргачлал ба дасгал хөдөлгөөн”, “Зохистой хооллолт”, “Илчлэг тооцох аргачлал” сургалтыг нийт 3 сум, 44 байгууллагын 1218 албан хаагчдад зохион байгуулан, 816 хүнийг танита аппаратаар үнэлэн хүн тус бүрд дасгал хөдөлгөөн, зөв хооллолтын талаар зөвлөгөө өгч ажилласан. Ахмадуудын дунд 2 дахь жилдээ “Шугаман бүжиг”, “Эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн”-ий тэмцээнийг зохион байгуулсан, 18 албан байгууллага, 3 суманд “Түмэн дасгал”, япон хүн бүрийн эрүүл амьдралын үндэс болсон тайсо-дасгалыг заасан. Үүнээс 7 байгууллага, 8 сум ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшсэн, шинээр бүжгийн 3 клуб нээгдсэн эерэг үзүүлэлттэй байна	
35		2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах	2021 - 2024		20000	Биеийн тамир, спортын газар нь Баянхонгор сумын хэмжээнд 10 спортын зааланд үйл ажиллагаа явуулж байна. Тус спорт заалуудад спортын 12 төрлөөр 500 орчим хүүхдүүдэд сонгон секц дугуйлан хичээллэж, мөн 53 албан байгууллага, төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Сумын арга зүйчид 7 хоног бүр төрийн албан хаагч, иргэдэд залны хуваарь гарган ажиллаж 72 удаагийн спорт, нийтийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж 560 гаруй хүнийг хамруулсан байна.	70%
36		3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах	2021 - 2024		2 1 0	Номундалай сургуулийн гадна спорт талбайн гүйцэтгэгчээр "Баянхонгор-Эко" ХХК тендэрт шалгарч газрыг тэгшлэх ажлыг хийсэн. Нийт 1.3 тэрбум төгрөгийн өртөгтэй бүтээн байгуулалтаас 2023 онд 240.000.000 төгрөгийг шийдвэрлэж хөлбөмбөгийн талбайг ашиглалтад оруулхаар төлөвлөж байна. Шинэжинст сумын спорт заалны барилга улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. Бөмбөгөр сумын спорт заалны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан.	100%

37	2.3.1. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2022 - 2024		100	<p>Аймгийн ИТХ-ын 2022 оны 8/10 тогтоолоор "Ковидын дараах сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөө" -г батлан хэрэгжүүлж, БШУЯ, БЕГ, БҮТ-өөс "Сургуульд суурилсан үнэлгээгээ"-ээр сурагчдын гүйцэтгэлийн аймгийн дундаж 2021 онд 41.6 хувьтай үнэлэгдсэн. 2022 онд 14 хувиар өсөж 55,6 хувь боллоо. Баянхонгор аймгийн төрийн өмчийн 26 сургууль бүгд шилэн кабелиар холбогдож БШУЯ-аас түгээж байгаа интернэт сүлжээнд холбогдсон. Интернэтийн хурдыг ихэсгэж 4мб болгосноор багш нар боловсролын нэгдсэн цахим сүлжээнд ажиллах, цахим контент боловсруулах зэргээр албан ажлаа хийх боломж бүрдлээ. Багийн 3 сургуульд агаараас хүлээн авдаг төхөөрөмж суурилуулсан. Үүний үр дүнд аймгийн бүх сургууль интернэт сүлжээнд холбогдсон байна БШУГ болон “Номундалай” сургууль дээр цахим контентын 19 сая төгрөгийн лаборатори сурлагын хоцрогдлыг нөхөх арилгахад ашиглах багш нарын цахим контент хийж бүтээх, боломжийг бүрдүүлсэн. Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих тоног төхөөрөмж бэлтгэх зардлыг улсын төсвөөр шийдэж Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Жаргалант, Баянхонгор сумын ЕБС -иуд Номгон, Эрдэнэмандал Эрдэм, Согоо Сейко, Гэгээн Сумади зэрэг 9 сургуульд 641 сая төгрөгийн иж бүрэн "Дижитал кабинет ашиглалтад оруулж сургалтад ашиглаж байна. Мөн 2022 онд Боловсролын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд улсын төсвийн 1 тэрбум 478, сая төгрөгийн зөөврийн компьютер, бичил лаборатори 5-ийг ЕБС, цэцэрлэгт нийлүүлж багш нарын 50 хувьд буюу 600 багшид зөөврийн компьютер олгосон сурлагын хоцрогдлыг арилгах, цахим сургалт, контент боловсруулах бололцоотой боллоо. Бага ангийн 120, дунд ангийн 40 контент бүгд 160 контент боловсруулж сургалтад ашиглан сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах ажлыг зохион байгуулсан.</p>	70%
38		2. "Чадварлаг багш" арга хэмжээний	2021 - 2024		100 300	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Хөтөлбөр төлөвлөгөө баталж хэрэгжилтийг хангах тухай" А/07 дугаар тушаалаар баталсан “Чадварлаг багш” арга</p>	70%

		төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх			<p>хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/596 дугаар захирамж арга хэмжээний төлөвлөгөөг баталж, цахим контент бэлтгэх, боловсрол судлалын чиглэлээр 10, "Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх нь", бага анги, монгол хэл, физик, математик, технологи, байгалийн ухаан, нийгмийн ухааны судлагдахууны багш нар, сургалтын менежер, захирлуудад зориулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 900, цэцэрлэгийн 240 орчим багш хамрагдсан байна. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах улс, аймаг, сургууль цэцэрлэг дээр мэргэжлээ дээшлүүлэх сургалтууд зохион байгуулагдаж Ерөнхий боловсролын сургуульд 223,1сая, цэцэрлэгт 45,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж зарцуулагдсан. Боловсролын үнэлгээний төвөөс багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж 317 багшид буюу нийт багш нарын 34,5 хувьд 10-25 хувийн нэмэгдэл олгогдсон. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх багш, сурагчдыг урамшуулах зорилгоор аймаг, сумын Засаг дарга, ИТХ-ын даргын нэрэмжит сорилыг 4 удаа зохион байгуулж 16,5 сая төгрөг, ЭЕШ-ын дүнгээр аймаг улсад 4 дүгээр байр эзэлж аймгийн ИТХТ-ийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор баталсан журмын болзлыг хангасан 8 сурагч, 10 багшид 17,5 сая төгрөг, сая урамшуулал олгосон нь өмнөх оныхоос 50 хувиар их урамшуулал олгож багш нарын цалин хөлсийг нэмэгдүүлсэн. Чадавараг багш арга хэмжээний хүрээнд 2023 онд улсын төрөлжсөн хичээллүүдийн олимпиадын 2 давааг зохион байгуулах, багш нарыг шагнаж урамшуулахад 6,5 сая төгрөг, "Мэргэжлийн бүлгийн хөгжил чадварлаг багш: бүсийн сургалтад 5,2 сая, Сургуулийн менежментийг сайуруулахад хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслахад 5,1 сая төгрөг нийт 16,8 сая төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэв</p>	
39	2.3.2. Хүүхэд бүрийг	1. Тусгай хэрэгцээт боловсролын багш	2021 -	40	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах, орчин нөхцөлийг бүрдүүлэх арга зүй олгох түгээн дэлгэрүүлэх сургалтыг 2022-2023	100%

	боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.	нарыг чадваржуулах сургалтад хамруулах	2024			онд 6 удаа зохион байгуулж нийгмийн ажилтан оролцлоо. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт MNS:6782-г хэрэгжүүлэх хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сан, БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /KOICA/-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл, Насан туршийн боловсролын төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй олгох сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. ЖАЙКА, СТАРТ төслийн зүгээс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нь тохируулан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга зүй”-н онлайн сургалтад Номгон, Эрдэм, Эрдэнэмандал, Бөмбөгөр, Өлзийт сумын сургуулийн 70 гаруй бага ангийн багшийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үйл ажиллагаанд тэгш хамруулахад анхаарах асуудал цахим сургалтыг сургуулийн нийгмийн ажилтан 30, дотуур байрын багш 20 албан хаагчийг хамруулан цахим хэлбэрээр зохион байгуулсан. Салбарын яамтай хамтран 6-р сарын 15-17-ны өдрүүдэд 5 сургуулийн хүүхэд хөгжлийн төвийг хариуцан ажилладаг сургуулийн нийгмийн ажилтан, багш нарт сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үйл ажиллагаанд тэгш хамруулахад анхаарах асуудал цахим сургалтыг сургуулийн нийгмийн ажилтан 30, дотуур байрын багш 20 албан хаагчийг хамруулан цахим хэлбэрээр зохион байгууллаа.	
40		2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог тохирох хэрэглэгдэхүүн, орчинг сайжруулах	2021 - 2024		2	Баянхонгор сумын Номгон ахлах сургууль, Өлзийт, Бөмбөгөр сумын сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон кабинеттай болоход Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, санхүүгийн болон тоног төхөөрөмжийн туламж үзүүлж жишиг сургалтын орчин бий болж хүүхдийн сурч боловсрох нөхцөл боломж бүрдсэн.	50%
41	2.3.3. Сургуулийн өмнөх	1. "Бага насны хүүхдийн цогц	2021 -		75	Бага насны хүүхдийн цогц хөгжил статейг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 25 ажлыг төлөвлөн эхний хагас	70%

	боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.	хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2024			жилд хийх 14 ажил нь бүрэн хэрэгжсэн Үүнд: 1. Тус бодлогыг хэрэгжүүлэхээр аймгийн Шимт мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулан 87 багш, 719 эцэг эхэд танхим болон онлайн-сургалт зохион байгуулсан. Бага насны хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, асаргаа хамгаалалын мэдлэг чадвар олгох, гэр бүлдээ дадал болгох сургалтыг зохион байгуулж чадваржуулав. Баянхонгор сумын 12 цэцэрлэгийн 33 багшийг зочинтой үйл ажиллагаанд урьж оролцуулж багш нар бүлэг бүртээ зохион байгуулж 1362 хүүхдэд сургалтаа зохион байгууллаа. “Амьдарлын зөв хэв маяг” мэргэжлийн хөгжлийн пейж хуудас нээн ажиллуулж “Шим тэжээлийн боловсрол” сургалтын багшийн 5 модуль, эцэг эхийн 5 модуль, постер 14, 9 шторк, зөвлөмж 3 бэлтгэн пэйжид байршуулсан.	
42		2. Бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчны сайжруулах	2021 - 2024		2	Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 35 цэцэрлэгийн 21 цэцэрлэг буюу 60 хувь нь хоол үйлдвэрлэлийн стандарт шаардлага хангасан гал тогоотой. Цэцэрлэгийн тогооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулж бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулаад байна.	30%
43		3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах	2021 - 2024		100	Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд 5 настай хүүхдийг сургуульд заавал хамруулах зорилт дэвшүүлж, мөн 5 настай хүүхдийг бүрэн хамруулах арга аргачлалыг боловсруулж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд 1824 хүүхэд хамрагдаж 1801 хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж нийт хүүхдийн 98 хувийг сургуулийн өмнөх үйлчилгээнд хамруулсан. Мөн багшийг бэлтгэн, бэлтгэл бүлгийн 52 багшийг хүүхдийн хөгжлийн судалгааны арга зүйд суралцуулж үр дүнгийн үнэлгээ тандалт судалгаа хийх аргад суралцуулж чадваржуулсан. 2023 онд аймгийн хэмжээнд 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт 93,3 хувьтай байна. Аймгийн Засаг дарга, БШУГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг цэцэрлэг бүрийн онцлогт тохируулан хийсэн.	70%

44		4. Хүүхэд харах төвийн үйлчилгээг тогтворжуулж, ясли байгуулах асуудлыг судлах	2021 - 2024		9	Хүүхэд харах төвийн үйл ажиллагаа албан ёсоор нээгдээгүй байгаатай холбогдуулан 2022-2023 оны хичээлийн жилд аймгийн төвийн 11 цэцэрлэгт 1нас 6 сартайгаас -2 нас хүртэлх хүүхэд хүлээн авах орчин нөхцөлийг бүрдүүлж 165 хүүхдийг цэцэрлэгт хүлээн авч ажиллаж байна. Түүнчлэн 2-3 настай хүүхдийг гэр бүлийн орчинд нь хөгжлийг дэмжих аргад эцэг эхийг суралцуулах сургагч багшаар 25 хүнийг бэлтгэн эцэг эх хүүхдээ өөрөө асран хамгаалах цогц үйлчилгээ үзүүлэх боломж, ойлголт өгөх сургалтад хамруулсан. 2023 оны хагас жилийн байдлаар улсын хэмжээнд ясли байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.	30%
45	2.3.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт, норм нормативийг мөрдүүлж, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.	1. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах	2021 - 2024		3	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин сайжруулах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд Баянбулаг сумын сургуулийн барилга , Баян-Овоо сумын ЕБС, цэцэрлэгийн барилга , Баянхонгор сумын Гэгээн сумади сургууль цэцэрлэгийн цогцолбор, 5 дугаар сургуулийн барилга ашиглалтад орж, "Номгон" ахлах сургуулийн хичээлийн байрны өргөтгөл баригдаж суудлын тоо 2540 -аар нэмэгдэж ээлжийн коэффициент хувиар буурлаа. Заг, Шаргалтжуут, Баянцагаан, Гурванбулаг сумын ЕБС -ийн хичээлийн байрны барилга 30-90 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. 2020-2022 онд Богд сумын сургуулийн хичээлийн байрны гадаад пасад, Бууцагаан сумын хуучин хичээлийн байрны дээврийн завсар , Жаргалант сумын сургуулийн гал тогоо, Баян-овоо, Эрдэнэцогт сумын сургуулийн дотуур байр, Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн их засвар тус тус хийгдэж 2023 онд Богд, Баян-Өндөр сумын цэцэрлэг, Баянхонгор сумын 5, 11, 12 дугаар цэцэрлэг, Баянговь, Заг сумын сургуулийн дотуур байр нь хийгдэж байна. БШУЯ-ны Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр 2 дотуур байр, 3 цэцэрлэг, 3 сургууль, НҮБ-ын хүүхдийн сан, Олон улсын хамтын ажиллагааны Койко байгууллага, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2 цэцэрлэг, 1 дотуур байр, 1 хичээлийн байр нийт 5 сургууль, 5 цэцэрлэг, 3 дотуур байрны барилга стандартын ариун цэврийн байгууламжтай болж орчин	70%

						нөхцөл сайжирлаа.	
46		2. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх	2021 - 2024		8	БШУЯ-ны захиалгаар "Эрдэнэт" үйлдвэрийн санхүүжилтээр тус аймагт стандартын ариун цэврийн байгууламж хийх ажлыг Бөмбөгөр, Заг сумын сургууль, дотуур байр, цэцэрлэг, Баян-өндөр сумын сургууль, дотуур байр, Баянбулаг сумын цэцэрлэгт 2021-2022 онд хийж ашиглалтад орууллаа. Богд, Шинэжинст сумын сургууль, цэцэрлэг, Хүрээмарал, Гурванбулаг сумын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж барих судалгаа хийгдлээ. Үүний үр дүнд 5 сургууль, 3 дотуур байр, 5 цэцэрлэг ариун цэврийн байгууламжтай болж нийт сургуулийн 71,4 хувь, дотуур байрны 72,7 хувь, хүүхдийн цэцэрлэгийн 88,5 хувь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон нь 2021 онтой харьцуулахад сургууль 15 хувиар, дотуур байр 10 хувиар, цэцэрлэг 7.5 хувиар өслөө.	100%
47		3. Цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулах	2021 - 2024		2	Баянхонгор сумын 11,12 дугаар цэцэрлэгийн гадаа талбайн тоглоомыг 26,490,000 төгрөгийн гадаа талбайн тоглоом, биеийн тамирын хэрэгслийг хүлээлгэн өгч тохижилтыг бүрэн хийсний зэрэгцээ Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгт НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр /17,6 сая төгрөг/ 3-5 настай хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжсэн жишиг орчныг бүрдүүлсэн.	100%
48	2.3.5. Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт "Үдийн хоол" олгох боломжийг	1. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангах	2021 - 2024		80	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй байх хүрээнд НҮБ хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 30,5 сая /Эрдэнэмандал/ төгрөгийн тоног төхөөрөмж, Улсын төсвөөр Эрдэм, Соого сейкео, Номундалай, Политехник коллеж, Бөмбөгөр сумд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Эрдэм, Соого сейкео, Өлзийт сумын сургуулийн гал тогоог иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан байна. Аймгийн хэмжээнд нийт 30 сургуулийн 20 сургууль буюу 66,6 хувь нь зориулалтын хоол үйлдвэрлэлийн танхимтай, 10	70%

	бүрдүүлнэ.					сургууль нь буюу 33,3 хувь зориулалтын хоол үйлдвэрлэлийн заалгүй байна.	
49		1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	2021 - 2024		650	2021-20223 онд Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 387 суралцагч суралцсанаас бага боловсролд 21, суурь боловсролд 174, бүрэн дунд боловсролд 192 суралцагч суралцаж, бага боловсролыг 4, суурь боловсролыг 63, бүрэн дунд боловсролыг 69 суралцагч эзэмшлээ. 2022-2023 оны хичээлийн жилд 473 суралцагч суралцаж байгаагаас бага боловсролд 30, суурь боловсролд 220, бүрэн дунд боловсролд 223 суралцагч байна. Суралцагчдын тоо өмнөх хичээлийн жилээс 17 хувиар нэмэгдсэн байна. Нийт суралцагчдын 36 нь хийдэд шавилан суудаг ламхай, 22 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна	100%
50	2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх	2021 - 2024		15000 2	“Алслагдсан бүс нутгийн хүүхдүүдэд зайнаас боловсрол олгох” төслийн хүрээнд Номгон сургуулийн БНОХ-т хамрагдаж буй зорилтот бүлгийн 15 суралцагчдыг хамруулан математик, монгол хэлний хичээлийн агуулгаар 2 түвшинд хувааж, 16 цагийн хичээлийг зайнаас технологийн дэвшилтэд тулгуурлан claasroom, google meet, зэрэг программыг ашиглан зохион байгууллаа. Уг төсөл нь уламжлалт аргаас татгалзан хүүхдийн сонирхолд нийцсэн дэвшилтэд i rad технологийг ашиглан хэрэгжиж буйгаараа онцлог байсан юм. Төслийн хугацаанд хүүхэд бүрийн ахиц өссөн. Насан туршийн боловсролын төвүүд харилцан тэргүүн туршлага солилцох ажлын хүрээнд БОАЖГ-тай хамтран ерөнхий боловсролын 7 сургуулийн дунд зохион байгуулсан “Эерэг хандлага-Гэрэлт ирээдүй” аяны цахим контентийг Номгон ТВ-тэй хамтран бэлтгэсэн. Тус цахим контентийг хэрэгжилтийн үе шат, зохион байгуулалт, хамрах хүрээ, цогц хөтөлбөр /сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, цуврал шторк, тайлант арга хэмжээ/, үнэлгээ, үр дүн, эргэх холбоо, тогтвортой байдлыг хангах, түншлэл хоорондын уялдаа холбоо, мэргэжил, ур чадвар дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх аргачлал, арга зүйн туршлага хүргэсэн. Түүнчлэн дараах насан туршийн боловсролын төвүүдийн сайн туршлагатай	70%

						танилцаж, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж байна. БЕГ-ын Насан туршийн боловсролын хэлтэс, E-Mongolia академитай хамтран Насан туршийн боловсролын салбарын удирдах ажилтан, багш нарын цахим ур чадварыг сайжруулах бүсчилсэн сургалтад 24 нэгжийн менежер, багш нар 95% ирцтэй хамрагдсан. Тус сургалтад хамрагдсан багш нар сум орон нутгийнхаа 25-45 насны 10-аас доошгүй иргэд буюу 240-өөс багагүй иргэдэд 30 цагийн хөтөлбөр бүхий цахим ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Насан туршийн боловсролын 24 нэгжээс 13 нэгж нь 157 иргэнд 57 удаагийн сургалтад хамруулаад байна.	
51	2.3.7. Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэнэ.	1. Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах	2021 - 2023		400	2023 оны 1 сард 2,5 жилтэй 13 мэргэжлийн 246 суралцагч төгссөн бөгөөд үүнээс 43,5 % нь ажлын байраар хангагдаж үүнээс барилгын салбарт /БӨУ, БЗЧ, Мужаан, Сан, Цахилгаан/ 18.2 хувь, үйлчилгээний салбарт /Үсчин, Авто, Хоол үйлдвэрлэл, Ардын гоцлол хөгжим/ 19,9 хувь, Хөнгөн үйлдвэрлэлийн салбар /Оёдол/- 5.2 хувь байна. 2023 оны 4, 5 сард 45 хоногийн түр сургалтыг Баянхонгор аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулж 8 мэргэжлээр 145 хүн хамруулан үнэмлэх олгосон үүнээс 75% нь ажлын байраар хангагдсан.	50%
52	2.3.8. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургуулийн орчны нэвтрэлт бүртгэлийн	1. "Онлайн кабинет" төсөл хэрэгжүүлэх	2021 - 2024		5	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжийг нэмэгдүүлж Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд 641,0 сая төгрөгийн өртөг бүхий "Дижитал танхимыг" Баянхонгор сумын Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Соого сейкео, Гэгээн Сумади сургууль, Бууцагаан, Өлзийт, Бөмбөгөр, Жаргалант сумын ЕБС нийт 9 сургуульд байгууллаа. Мөн ухаалаг самбарыг ЕБС-д нийлүүлж сургалтын орчныг бүрдүүлсэн. Мөн боловсролын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд бичил лабораторийг Баянхонгор сумын 5 дугаар сургууль, Богд, Эрдэнэцогт, Галуут, Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлсэн.	70%

53	системийг шинээр нэвтрүүлнэ.	2. Багш нарыг компьютер, планшетаар хангах	2021 - 2024		300	Багш нарыг зөөврийн компьютерээр хангах үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсролын Ерөнхий газраас аймгийн ЗДТГ-аар дамжуулан Саммит компьютер технологи ХХК-тай гэрээ байгуулж компьютержуулах нийт 1497,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 100 хувь 600 компьютер нийлүүлж дуусгасан. Үүнээс: Зөөврийн компьютер 1,385.9 сая, цахим контентийн лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж 111,1 сая төгрөгөөр нийлүүлсэн. Цахим контент лаборатори байгуулахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Санкомаркетинг монголиа ХХК-тай гэрээ байгуулж нийт 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 100 хувь нийлүүлж дуусгасан. ЕБС-ийн 2022 оны санхүүжилтэд нэмэлтээр нөхөн хангалтын санхүүжилт 963,6 сая төгрөг суугдаж БШУС-ын 2022 оны 11 сарын 21-ны 1а/5624 тоот чиглэлийн дагуу хүүхдийн тооноос хамаарсан 1 толгой компьютер болон сурагчийн сургалтын планшетаар хангах цахим сургалтын тэнхим бүрдүүлэн ажилласан.	100%
54	2.4.1. Худалдаа үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулна.	1. Сургалтын орчныг сайжруулж, боловсон хүчнийг чадавхжуулах	2021 - 2024		150 сая	Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн менежментийг өөрчилж хөдөө аж ахуйн их сургуулийн салбар сургууль болгон улирлын болон эчнээ ангиудыг нэн шаардлагатай мэргэжилтнүүдээр нээн элсэлтээ авч байна. Сургуулийн барилга барих газрын асуудлыг шийдвэрлэж зураг төсөв хийгдсэн Баянхонгор аймагт ХААИС-ийн салбар сургууль бий болж байгаатай холбоотой ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн захирал тус аймагт ажиллаж хамтран ажиллахаар болсон. Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр боловсролын салбарын тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	30%
55	2.4.2. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл	1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах	2021 - 2024		100	Аж ахуй эрхлэлтийг дэмжих "Бизнесээ эхэл-бизнесээ хөгжүүл" сургалтыг "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 250, төсөл хөтөлбөрт хамрагдсан 264, нийт 514 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, иргэдийг хамруулж чадавхжууллаа. Арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 14.724.00 төгрөгийг зарцуулсан. Сургалтад хамрагдсан иргэдийн тоо өмнөх оноос 211 хүнээр өссөн байна. 2023 онд аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион	

	эрхлэгчдийг дэмжинэ.					байгуулах сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажил явагдаж байна.	
56	2.4.3. Шинэ мэдлэг, патент гаргасан эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн судалгааг гарган бүртгэлжүүлж, урамшуулна.	1. Эрдэм шинжилгээний багийг байгуулж, шинэ мэдлэг патентийг бий болгох	2022 - 2024		4	Аймгийн Засаг даргын "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах тухай" 2023 оны А/196 захирамжийн нэгдүгээр хавсралтаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, хоёрдугаар хавсралтаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн дүрэмийг тус тус баталсан. Шинжлэх Ухаан Технологийн Үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан "Монголын инновацийн 7 хоног-2023" арга хэмжээ, "Инновацийг орон нутагт" сэдэвт мэргэжил, арга зүйн семинарт аймгийн Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар оролцлоо. Грант олгох үйл ажиллагаа 8 сард болно.	
57	2.5.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралаа авч явах дадал, хэвшлийг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.	1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажлын байр бий болгох, ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулах	2021 - 2024		500	Аймгийн бүтээн байгуулалтын ажлууд буюу ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, хог хаягдал ангилан ялгах, засмал зам дагуух хайрга чулууг түүх, динозавртай паркийн хашааг буулгах зэрэг аймгийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2022, хувийн аж ахуй нэгж, байгууллага болон бусад хөтөлбөр, төслийн хүрээнд байнгын ажлын байранд 1381, нийт 3403 ажлын байрыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, мэдээлсэн. Шинээр бий болсон ажлын байрны 692 буюу 31.7 хувь нь байнгын ажлын байр эзэлж байна. Түр ажлын байр бий болгоход Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 620.0 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны санхүүжилтээс 480.0 сая төгрөгөөр, түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо 1406 хүнээр нэмэгдсэн байна. Энэ нь Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих арга хэмжээнд 980 иргэн хамрагдаж, түр ажлын байраар хангагдсан нь нөлөөлсөн. Энэ оны хагас жилийн байдлаар нийтийн эзэмшлийн газрын шороо бүхий талбайг эко хавтан, замын бродюр, явган замын хавтангаар бүрэх, ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, шинэ суурьшлын бүс болон хотын	

						төвийг тойрсон ойн зурвас, шинээр байгуулагдаж буй ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа хийх ажилд бүртгэлтэй, ажилгүй 364 иргэнийг түр ажлын байраар, 51 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, нийт 415 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан.	
58	2.5.2. Өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.	1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх	2021 - 2024	250	Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 2021 онд “Цар тахалын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг 5 хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийт 1301 хүнд 555,7 сая төгрөг зарцуулсан. Үүнээс байнгын болон түр ажлын байранд нийт 1243 иргэн зуучлагдсан. 2022 онд “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг 7 хөтөлбөр арга хэмжээнд давхардсан тоогоор 4200 иргэн хамрагдаж 1.9 тэрбум төгрөг зарцуулсан. Хөтөлбөрүүдийн үр дүнд байнгын ажлын байр 463, түр ажлын байр 1714 бий болсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 30.9 хувиар өсч, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 29.2 хувиар нэмэгдсэн. Энэ оны хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 64 төсөл хүлээн авч хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч 21 иргэнд 104.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Бичил бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 30-аас дээш настай иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг журмын дагуу сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. Нийтийг хамарсан, бүтээн байгуулалтын ажилд		

						ажил идэвхтэй хайгч 364 иргэнийг хамруулж, түр ажлын байраар хангасан.	
59	2.5.3. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана.	1. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг таниулж, нийгмийн баталгааг хангах	2021 - 2024		7820	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Гэрээний хэрэгжилтийн дундаж 95.6 хувьтай байна. Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч мөн ажил хөдөлмөр эрхэлдэггүй 12188 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 1409 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Даатгалд хамрагдсан 13597 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 6759, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1826, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 1253, оюутан 21, бусад 2329, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 1409 байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон тодорхой хөдөлмөр эрхэлдэггүй иргэд 5826, малчин 12273, оюутан 1373, нийт 19472 даатгуулагч эрүүл мэндийн заавал даатгалд хамрагдсан нь нийт /40860 хүн/ хамруулбал зохих иргэдийн 47.6 хувь байна. Шинээр сайн дурын нийгмийн даатгалд даатгуулагчдын хувь өмнөх онуудаас 2.9 хувиар, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагч 3950 хүнээр буюу 5.1 хувиар тус тус өссөн байна. Энэ оны хагас жилийн байдлаар 5970 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулж, нийгмийн баталгааг нь хангасан.	
60	2.5.4. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх	1. Хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулах	2021 - 2024		200	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа иргэдийн судалгаагаар хөдөлмөрийн насны 1100 иргэн байгаагаас ажил идэвхтэй хайгч 609 иргэн байна. Дээрх иргэдээс байнгын ажлын байранд 28 иргэн, аймгийн бүтээн байгуулалтын ажил буюу мод тарих, явган замын өнгөт хавтан суурилуулах, хог хаягдал ангилан ялгах, цэвэрлэх, улирлын чанартай түр ажлын байранд 300 иргэнийг тус тус зуучилж, ажлын байраар хангасан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 220, аж ахуй эрхлэлт, төсөл хөтөлбөрийн сургалтад 50, амьдралын итгэл үнэмшил олгох, хөдөлмөрт бэлтгэх,	

	чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.					авьяасыг нь дэмжих бүлэг үүсгэх сургалтад 160, өдөрлөг яармаг, бусад арга хэмжээнд 349, 779 иргэнийг хамруулж чадавхжууллаа. Нийгмийн халамжийн сангийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 2021 онд 6 бүлгийн 14 гишүүнийг 8.7 сая төгрөгийн, 2022 онд 4 бүлгийн 8 гишүүнийг 6.9 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэгт хамруулж, түр ажлын байраар хангасан. Дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 1136 иргэн хамрагдсан. Энэ оны хагас жилийн байдлаар нийтийн эзэмшлийн газрын шороо бүхий талбайг эко хавтан, замын бродюр, явган замын хавтангаар бүрэх, ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, шинэ сууршлийн бүс болон хотын төвийг тойрсон ойн зурвас, шинээр байгуулагдаж буй ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа хийх ажилд 364 иргэнийг хамруулж, түр ажлын байраар ханган 40.8 сая төгрөгийн урамшуулал олгосон. Дээрх иргэдийн 113 нь буюу 30 хувь нь нийгмийн халамжийн бодлогын хүрээнд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэд байна.	
61	2.5.5. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар хуримтлалтай болгох арга зүйд сургаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болгон "Хуримтлалтай хүүхэд" арга	1. "Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох"	2022 - 2024		10000	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор ирээдүйн өв сангийн тухай хуульд заасны дагуу хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журмын дагуу "Хүүхэд бүрд хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" зорилтыг дэвшүүлэн ажиллаж байсан боловч Уг тогтоолыг Засгийн газрын 2023 оын 01 сарын 05-ны өдрийн 11-р тогтоолоор хүчингүй болгож хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам шинэчлэгдэж тус арга хэмжээ хэрэгжээгүй болно. Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 0-18 хүртэлх насны 32871 хүүхдэд 3285.18 сая төгрөгийг олгосон байна.	

	хэмжээг хэрэгжүүлнэ.					
62	2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах	1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах	2021 - 2024		8	Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй, байгалийн түүхийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа түүх соёлын хөдлөх дурсгалуудын төмөр тавиурыг даавуун бүрээсээр бүрсэн, сан хөмрөгт ашиглалтгүй байсан хүндрүүлэгчтэй сейфийг ашиглалтанд оруулж цөөн тооны үзмэрийг хадгалах орчин сайжруулав. Нийт 1602 ш үзмэр эд өлгийн зүйлийг тусгай уут хайрцганд хийж хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Шинэжинст сумын сарлагтай хадны оршуулгын дурсгалт газарт авран хамгаалах малтлага, судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Сумдын Засаг дарга, Соёлын төв, Нутгийн малчин иргэдийн гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж орон нутгийн түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад анхаарч ажиллалаа.
63	хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна.	2. Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийг бүртгэх	2021 - 2024		45	Баянхонгор сумын нутагт амьдардаг 2 иргэний төвд барын аргаар барлаж бүтээсэн 3 судрыг Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6, 7, 8 дугаар зүйлд заасны дагуу соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 541 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийн маягтаар бүртгэн авсан.
64		3. Биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах	2022 - 2024		3	1.“Хонгор нутгийн соёлын биет бус өвлөн уламжлагч нарыг алдаршуулах” цуврал нэвтрүүлэгт Монгол ардын уртын дуучин, уран сийлбэрчин , арьс шир, эсгий урлалын өвлөн уламжлагчдын арга, ухааныг аймгийн телевиз, цахим сүлжээгээр иргэд, хүүхэд залуучуудад сурталчлан ажиллалаа. .2.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7.1.9-д заасанчлан үндэсний наадам, уламжлалт тоглоом наадгайн нэгэн төрөл болох “Дөрвөн бэрх” тоглоомыг аймгийн ахмадын холбоотой хамтран зохион байгуулж 60 гаруй ахмадыг хамруулан арга хэмжээ зохион байгуулан шагнаж

						урамшууллаа.	
65	2.6.2. Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадвар, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.	1. Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах	2021 - 2024		70 170	Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн ур чадварыг хөгжүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн бодлогын хэлтэс, Соёл урлагийн газар хамтран онолын болон практик хосолсон сургалтыг орон нутагт зохион байгуулж 80 уран бүтээлчдийг хамруулсан.Соёл урлагийн салбарын нийт албан хаагчдад “Соёлын менежмент-үйлчилгээний соёл” онлайн сургалтыг 2023.05.03-нд зохион байгуулсан. Соёл урлагийн салбарын мэргэжлийн бус соёлын ажилтнуудыг СУИС-д эчнээ ангид суралцуулан мэргэжилтэй ажилтны хангамжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд аймгийн хөгжимт драмын театраас бакалаврын ангид 3, магистрантурт 1 албан хаагч тус тус суралцаж байна.Мэргэжилтэй боловсон хүчний хангалт 64 хувьтай байна.	
66		2. Соёлын төвийн бүтэц орон тоог нэмэгдүүлэн соёлын өвийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх	2022 - 2023		6	Аймгийн хэмжээнд 19 сумын соёлын төвөөс Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг,Гурванбулаг, Эрдэнэцогт, Баян-Овоо сумын соёлын төвүүд соёлын өвийн үндсэн орон тооны ажилтан ажиллаж, Баян-Өндөр, Галуут, Жинст, Заг, Богд, Баацагаан зэрэг 6 сумын соёлын төвүүдэд соёлын өвийн ажилтны орон тоог хавсарсан байдлаар шийдсэн. Баянговь, Баянлиг, Шинэжинст, Жаргалант сумдад төсөв хүрэхгүй шалтгаанаар соёлын өвийн ажилтны орон тоо шийдэгдээгүй байна.	
67	2.6.3. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. "Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2022 - 2024		70	"Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Соёлын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар баталсан "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилгын хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусган 06 дугаар сард удирдлагын зөвлөлийн хурлаар батлуулахаар төлөвлөсөн.	

68	2.6.4. Соёлын төвүүдийн орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Соёлын төвүүдийн барилгыг шинэчлэх, иргэдийг соёлын боловсролын судалгааг хийх	2021 - 2024		0 40	Хүрээмарал, Заг, Баянлиг, Галуут, Өлзийт, Жинст, Эрдэнэцогт, Бууцагаан, Гурванбулаг, Шинэжинст сумдын соёлын төвийг шинээр барьж ашиглалтад оруулж тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг үе шаттайгаар шийдвэрлэж Баянлиг Хүрээмарал сумдын соёлын төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг нийлүүлэх Чугма далай ХХК, Дэвших болор ХХК -тай тус тус гэрээ байгуулж 06 сард нийлүүлэхээр хүлээгдэж байна. Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй, байгалийн түүхийн музейн шинэ барилгын төсвийг 7.415.198.600 төгрөгийн өртөгтэйгээр шинэчлэн, төсвийг Лайн констракшн ХХК-аар хийлгэж Соёлын яаманд хүргүүллээ.	
69		2. Зарим сумдын соёлын төвийн орон нутаг судлах танхимыг өргөжүүлэх	2022 - 2023		1	Баян-Овоо сумын Музейн барилгын ажил 2022 онд орон нутгийн хөгжлийн сангаас 298.0 сая төгрөгийн санхүүжилтээр шийдэгдэж 2023 оны 2-р хагаст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байгаа бөгөөд барилгын ажил 90% явагдаж байна.	
70		3. Соёлын төв, мэргэжлийн урлагын байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах	2021 - 2024		2	Аймгийн Хөгжимт драмын театр, хүүхдийн Тэмүжин театрын тоног төхөөрөмжийг шинэчлэх тендерт ЭЭЛГРАНД ХХК шалгарч ХДТ-ын техник хэрэгсэл 100 хувь нийлүүлэгдэж хүүхдийн Тэмүжин театрт нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг 06 сард нийлүүлэхээр хүлээгдэж байна. Соёлын төвүүд болон мэргэжлийн урлагийн 4 байгууллагын хэрэгцээт тоног төхөөрөмжийн 1023.0 сая төгрөгийн судалгаа гарган Сангийн яаман хүргүүлсэн.	
71	2.6.5. Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг	1. Иргэдийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах	2021 - 2024		90 1.5	“Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийн дагуу Нийтийн номын сан, Соёлын төв, Соёлын ордны 20 байгууллагаас сум багийн Засаг дарга түүний Тамгын газар, Боловсролын байгууллага, Зохиолчдын холбоотой хамтран, иргэд олон нийтэд “Номын баяр” арга хэмжээг зохион байгуулсан. Нийтийн номын сангийн ажилчид Хангайн бүсийн 8 суманд томилолтоор ажиллаж сум бүрт нэг өдрийн арга хэмжээ зохион байгуулж ард иргэдийг соён гэгээрүүлэх олон төрөлт ажлыг хийж	

	өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна.					гүйцэтгэлээ. Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд Мэдээлэл сургалт сурталчилгааны чиглэлээр 30 төрлийн арга хэмжээ, Үзүүлэн таниулах чиглэлээр 165 төрлийн үзэсгэлэн, Уралдаан тэмцээн 75, Уулзалт хэлэлцүүлэг 33 арга хэмжээ, Номын үзэсгэлэн, худалдаанд давхардсан тоогоор 6544 номыг таниулж, цахим сурталчилгааны ажлуудыг зохион байгуулсан. “	
72	2.6.6. Аймгийн түүхийн музейн барилгыг барьж биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна.	1. Хөдлөх дурсгалын мэдээллийн санг баяжуулах	2021 - 2024		800	Нхний хагас жилийн байдлаар аймгийн музейн сан хөмрөгт 2.956.000 төгрөгийн үнэлэмжтэй 55 ширхэг үзмэр эд өлгийн зүйлээр музейн сан хөмрөгийг баяжуулсан байна	
73	бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна.	2. Биет бус өвийн мэдээллийн санг баяжуулах	2021 - 2024		11	Аймгийн хэмжээнд биет бус өвийн мэдээллийн санд нийт 315 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч бүртгэлтэй байдаг бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 202 өвлөн уламжлагчийг уг бүртгэлд хамруулсан. Судалгааны хоёр дугаар үе шат сүүлийн хагас жилд хийгдхээр төлөвлөж байна	
74	2.7.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	1. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" зорилтот төсөл хэрэгжүүлэх	2022 - 2024		5500	Аймгийн БШУГ, ГБХЗХГ хамтран хүүхдийн эрх, үүргийг сургууль, цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах, хүүхэдтэй ажиллах аргазүй хандлагаа өөрчлөхөд багш, эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн тасралтгүй тогтмол, үр дүнд хүрэхүйц ажил арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх зорилго бүхий "5X"-гийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, аяны хүрээнд 8 төрлийн сургалт 4 төрлийн нөлөөллийн ажил зохион байгуулж 6581 албан хаагч, эцэг эхчүүдийг хамруулсан. Сургуулийн нийгмийн ажилтнуудад сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгөх арга зүйн сургалтыг "Хөөрхөн зүрх" ТББ-тай хамтран 2 өдрийн сургалт зохион байгуулж, 32 нийгмийн ажилтан хамрагдаж гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөж хохирсон насанд хүрэгч ба хүүхдүүдэд анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадвар эзэмшив. □ Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх анхан шатны арга техник болох "ЗУРГАН ОНОШЛОГОО" арга зүйн сургалтыг 29	

					нийгмийн ажилтан 43 цэцэрлэгийн арга зүйч нарыг хамруулан цахим хэлбэрээр зохион байгуулсан. □ “Миний гэр бүл”, “Миний ертөнц” хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан сургуулийн сурагчдын асран хамгаалагч гэр бүл, хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах зорилгоор Монголын Хүүхэд, гэр бүл судлалын академийн тэргүүн, МУ-ын гавьяат багш, доктор доктор(Ph.D), дэд профессор, хүүхэд, гэр бүл, судлаач Х.Баавгайтай хамтран сургалт зохион байгуулж, нийгмийн ажилтнууд гэр бүлд суурилсан үйлчилгээ үзүүлэх арга зүйтэй болж сургуулийн сурагчдад засал үйлчилгээ хийхэд чухал ач холбогдолтой байсан.	
75	2. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах	2021 - 2024		2500	Орон нутгийн 19 сумын иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчилах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ажлыг зохион байгуулахын зэрэгцээ залуу, дунд насны гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, тогтвортой бат бөх гэр бүлийг төлөвшүүлэх, хүүхэд, иргэд, олон нийтийг хүүхэд хамгааллын талаар мэдлэгжүүлэх, нийгмийн сэтгэл зүйд хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага төлөвшүүлэх, зөрчил мэдээллийг хүлээн авч газар дээр нь шуурхай шийдвэрлэх, хуулиар хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчдийг ажлын байранд нь чадавхижуулах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хамгаалах үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих, хүүхдийг эрсдэлд нөхцөлд оруулж болзошгүй орчны аюулгүй байдалд үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг газар дээр нь очиж, түргэн шуурхай шийдвэрлэх, зөвлөн туслах зорилгоор “Амар тайван гэр бүл” нэгдсэн өдөрлөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газартай хамтран 20 сумд зохион байгуулж, өдөрлөгийн хүрээнд нийт иргэдрүү чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн 11 сургалт, хэлэлцүүлэг, үүрэг хүлээгчдэд чиглэсэн 1 сургалт, хүүхдүүдрүү чиглэсэн эх оронч үзэл төлөвшүүлэх, сайн дурын ажилд уриалах, үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах чиглэлээр 3 сургалтыг тус тус зохион байгуулсан.	

76		3. Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах	2021 - 2024		70	Аймгийн Хүүхдийн нэгдсэн чуулган нь жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулагддаг. Хугацаа болоогүй.	
77		5. 4 настай хүүхэдтэй аавуудад чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх	2021 - 2024		50	Аймгийн ГХУСАЗСалбар зөвлөлтэй хамтран орон нутагт хэрэгжүүлэх сургалтын модулыг шинэчлэн боловсруулсан.2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролыг түшиглэн хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	
78	2.8.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно.	1. "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх.	2021 - 2024		60	"Хонгорын гэр бүл" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 2 зорилт 24 арга хэмжээтэйгээр боловсруулан аймгийн Засаг даргын 2022 оны А/265 захирамжаар батлуулан сумдад хүргэсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулж нийт 2735 хүнд хүрсэн байна. Гэрлэлт, гэр бүлийн тухай ойлголт, Гэр бүл төлөвлөлт, Өрхийн төсөв сэдэвт сургалтуудыг 15-34 насны залуучуудад, Гэр бүлийн харилцаа, Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтуудыг 20-45 насны иргэдэд, Гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг,Гэр бүлийн эрүүл мэнд сэдэвт сургалтыг 40-өөс дээш насны гэр бүлүүдэд тус тус зохион байгуулсан. Сургалтанд хамрагдсан иргэдийг хуйсээр ангилвал эрэгтэй 952, эмэгтэй 1783 байна. "Амар тайван гэр бүл" нэгдсэн өдөрлөгийн хүрээнд сумдад ажиллахдаа 2022 онд "Гэр бүлийн боловсрол олгох" сургалтын сургагч багшаар бэлтгэгдсэн 48 хүнийг идэвхжүүлэх, дадлагажуулах ажлыг зохион байгууллаа. Мөн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Хуримын ордон" ашиглалтанд орж "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн.	
79	2.8.2. Хуримын ордныг	2. Хуримын ордныг түшиглэсэн гэр	2022 -		2	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ордон буюу "Хуримын ордон ашиглалтанд орсноор байгууллагын дэргэд "Гэр бүлийн зөвлөгөө	

	ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна.	бүлийн зөвлөгөө өгөх төв, сумдад загвар төв байгуулах	2024		300	өгөх" төвийг MNS 6417:2013 стандартын дагуу байгуулж үйл ажиллагааг эхлүүлж, төвөөр дамжуулан Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхдийн эрх, хамгааллын мэргэжилтэн, Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хагас жилийн байдлаар 25 насанд хүрэгч, 19 хүүхэд / хүйсээр ангилвал 27 эмэгтэй, 17 эрэгтэй/ нийт 44 хүнд үйлчилгээ үзүүлсэн.	
80		3. Монголын гэр бүл судлаачид, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021 - 2024		190	Монголын гэр бүл судлаачид, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн Гэр бүл судлалын танхимтай хамтран орон нутагт 23 "Гэр бүл судлалын магистр" бэлтгэсэн. Бэлтгэгдсэн магиструудтай хамтран Гэр бүлийн боловсрол олгох 8 моудль сургалтыг орон нутгийн онцлогт тохируулан бэлтгэсэн бөгөөд 689 иргэнд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. Мөн "Хүмүүжлийн эерэг арга" видео уралдаан зарлах, "Олон Улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх" зэрэг арга хэмжээнүүдийг хамтран зохион байгууллаа.	
81	2.8.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2. "Хариуцлагатай 100 залуу элч"- ийг бэлтгэх	2021 - 2024		8000	"Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал" сэдвийн хүрээнд 300 залууд сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулан ажиллаа. Бүгд залуусын төлөө – Залуус бүгдийн төлөө төслийн хүрээнд залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 ТББ-ын төлөөлөл 35 залууд "Төрийн бус байгууллагын стратеги" сургалтыг 2 өдөр танхимаар зохион байгуулсан. ХХҮГ-тай хамтран залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд түр ажлын байранд нийт 124 залууг холбон зуучлан ажилласан.	

82	2.8.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ.	2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх	2021 - 2024		80	Жендэрийн салбар хороодын гишүүдийг чадавхжуулах бүсийн сургалтыг зохион байгуулсан.	
83	2.8.5. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж,	1. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	2021 - 2024		800	Өвгөнжаргалант хүүхдийн зуслангийн 2023 оны ээлжийн хуваарийг гарган пэйж хуудас, телевизийн сувгуудаар байршуулан мэдээллийг түгээсэн. Амрагч хүүхдүүдийн бүртгэлийг эхлүүлсэн. Зуслангийн нэг ээлжинд 100-200 хүүхдийг амраахаар төлөвлөж байна. Нэгдүгээр ээлж 2023.06.12-нд эхэлнэ.	
84	сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана.	2. Хөдөлмөр зусланг ажиллуулах	2021 - 2024		3	Зуслангийн 9-р ээлжийг Хөдөлмөр зуслангийн ээлж болгохоор төлөвлөн, хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Хөдөлмөр зусланг хэрэгжүүлснээр хүүхдэд эх оронч үзэл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
85		3. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэн тохижуулах	2021 - 2024		40	Хүүхдийн авьяас чадвар бие бялдар, ур чадварыг хөгжүүлэх, үндэсний өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ-ын хүүхдийн сантай гэрээ байгуулж 25 сая төгрөгний санхүүжилтийг авснаар хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, зуслангийн хөгжлийн үйлчилгээний чанаар хүртээмжийг сайжруулсан. Үүнд: Морин хуур-10, Лимбэ-2, Шанз-2, Ёочин-2, Хуучир-2, Ятга-2, Мандолин-10, Гитар-10, Волойболын бөмбөг-5, Сагсан бөмбөг-5, Хөл бөмбөг-3, Теннисний ширээ-2, Волойболын тор-2, Аркет-4, Танин мэдэхүйн тоглоом-10, Монгол гэрийн угсардаг тоглоом-10, Номын сан байгуулах ном-180 ширхэгийг шинээр авсан.	
86	2.8.6. Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг”	2. Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг	2021 - 2024		10	Аймгийн хүүхдийн зөвлөлийн тэргүүн болон 10 дэд хорооны тэргүүн, аймгийн төвийн 10 ерөнхий боловсролын сургууль, политехник коллежийн хүүхдийн зөвлөл, Мини парламент, Infinity real клуб, Эко манлайлал, Лидер сурагч академи, Улаан	

	хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ.	идэвхжүүлэх				загалмайн дэргэдэх "Охидын клуб", Судлаач хүүхэд клуб зэрэг 18 ХОӨУБ-ын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа танхимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 200 хүүхэд хамрагдсан. Мөн аймгийн Хүүхдийн зөвлөлийн санал санаачилгыг дэмжин дараах ажлуудыг хамтран зохион байгуулсан. Үүнд: Илтгэлийн уралдаан - ХОӨУБ-ын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа Охидын нэгдсэн өдөрлөг арга хэмжээ - Мартагдашгүй март арга хэмжээ - Сэтгэлийн гал сайн дурын арга хэмжээ - Уур амьсгалын өөрчлөлт эсээ бичлэгийн уралдаан "Найз байя" аяны хүрээнд нийт 156 оролцооны байгууллагын 400 гаруй гишүүдийг "Үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхалт" сэдэвт сургалтад хамруулж чадавхжуулсан. Мөн оролцооны байгууллагын төлөөлөл 100 хүүхэд "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээний парад жагсаалд оролцож дуу хоолойгоо илэрхийлсэн.	
87		3. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах	2021 - 2024		35 , 85	Сумдын хамтарсан багуудад газрын даргын албан бичгээр зөвлөмж хүргүүлж, ЗДТГ, ЭМТ, Соёлын төв, сургууль, цэцэрлэгийн анхаарах асуудлыг нэг бүрчлэн тусгасан бөгөөд нийт 50-60 анхаарах асуудлыг тусгаж өгсөн байна. Мөн Галуут, Гурванбулаг, Баянлиг, Жинст, Бууцагаан, Бөмбөгөр сумдын хамтарсан багийн гишүүдийг арга зүйгээр хангах, газар дээр нь зөвлөн туслах ажлыг тус бүр 1 удаа зохион байгуулсан. Хамтарсан багийн үнэлгээг 5 жилээр хийхэд ХТУ-ы кейс шийдвэрлэлт жил бүр 2-5 хувиар өссөн, Хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо 2000-5000-аар нэмэгдсэн, төсөв 2.5-4.5 саяаар өссөн зэрэг эерэг үзүүлэлтүүд харагдаж байна.	
88	2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад	1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	2021 - 2024		25	Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтын хүрээнд "Гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг" сургалтыг шинэчлэн боловсруулсан. Хагас жилийн байдлаар Галуут, Эрдэнэцогт сумын 660 хүн, Чандмань ХХК-ий ажилтан албан хаагчид 25 хүн, ЕБС-ийн 8-9-р ангийн 18 сурагчид, Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан сумын 344 хүн нийт 1029 хүнд "Архивын тасаг, "Уг удам судлах танхим"-тай хамтран "Гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг", "Угийн бичиг	

	түгээн дэлгэрүүлсэн байна.					хөтлөх арга зүй" сургалтуудыг зохион байгууллаа. Мөн сум орон нутгийн ураг удмын ном, угийн бичгээ хөтөлдөг өрхүүдийн туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх, шинээр угийн бичгээ хөтөлж эхэлсэн өрхүүдэд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж 36 өрхөд хүрч ажилласан.	
89	2.8.8. Сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Сайн дурын үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН-үүдийг хооронд нь холбох, үнэлэх системийг сайжруулна.	1. Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах	2021 - 2024		70	"Хүүхдийн спортын VII их наадам" Баянхонгор аймагт зохион байгуулагдахтай холбогдуулан нийт 100 сайн дурын ажилтныг бүртгэж, баталгаажуулан бэлтгэж байна.	
3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
90	3.1.1. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган татвар төлөгчдийг бүрэн хамруулж татварын орлогын суурийг нэмэгдүүлнэ.	1. Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах	2021 - 2024		1150	Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийн урьд оны хуримтлагдсан өр, тайлант оны ногдлыг хураан барагдуулах, татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгаж, холбогдох хууль, журмын дагуу газрын төлбөрийн ногдол үүсгэх, төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Татварын хэлтэс, Прокурорын газар, Газрын харилцаа барилга, Хот байгуулалтын газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 2 сарын хугацаатай "Газрын төлбөрийн урьд оны хуримтлагдсан өр, ногдлыг барагдуулах удирдамж"-ийг баталж, судалгаа, мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Хуулийн этгээд, хувь хүний эзэмшилд байгаа авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийн төлөлтөд хяналт	

					тавих, бүртгэл судалгааг тулгах, татвар төлөгчийн тээврийн хэрэгслийн өрийг барагдуулах зорилгоор аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн тасагтай хамтран "Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураалтын ажлыг эрчимжүүлэх" арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 01–ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулан ажиллаж байна. АТБӨЯХ-ийн албан татвар төлөгчийн бааз суурийг шинэчлэх, үнэн бодитой тоо мэдээг бий болгох зорилгоор Зам тээврийн хөгжлийн яамны 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07/5809, 1/1583 дугаар тушаалын дагуу АТҮТ-ийн БХР аймаг дахь салбартай хамтран сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, албан татвар төлөөгүй 5639 тээврийн хэрэгслийн судалгааг сум тус бүрээр гаргаж хэлтсийн даргын албан бичгээр сумдын байцаагч нарт хүргүүлж, энэ ажлын хүрээнд АТҮТ-ийн БХР аймаг дахь салбарын техникийн үзлэг оншилгооны багтай хамтарч 15 суманд 1267 татвар төлөгчийн тээврийн хэрэгслийн хасагдах материалыг хүлээн авч албан татвар төлбөрийг нөхөн төлүүлж АТҮТ-ийн төвийн баазаас хасуулав.	
91	2. Газрын төлбөр ногдуулалт нэхэмжлэлийг 100% хийж дуусгах, шугам сүлжээнээс газрын төлбөр авч татварт хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулж бааз суурийг нэмэгдүүлэх	2021 - 2024		380	ГХБХБГазраас 2023 онд 11963 татвар төлөгчийн 23087 нэгж тайлбайд 664.0 сая төгрөгийн газрын төлбөрийн нэхэмжлэх үүсгэсэн ба Прокурорын газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэс хамтран 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 2 сарын хугацаатай “Газрын төлбөрийн урьд оны хуримтлагдсан өр, ногдлыг барагдуулах удирдамж”-ийг баталж, судалгаа, мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийн урьд оны хуримтлагдсан өр, тайлант оны ногдлыг хураан барагдуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэдээллийн зөрүүг арилгаж, холбогдох хууль, журмын дагуу газрын төлбөрийн ногдол үүсгэх, төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх	

						зорилготой бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өөрийн эзэмшиж, ашиглаж буй газрын өмнөх онуудын болон тайлант хугацааны төлбөр тооцоогоо барагдуулж, мэдээллийн зөрүүтэй байдлыг залруулахыг мэдэгдэж, мэдээллээр ханган ажиллаж байна. Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан нөхцөл болзлыг удаа дараа зөрчсөн, тухайлбал эзэмшил газраа 2 жил дараалан хүндэтгэн үзэх шалгаангүйгээр ашиглаагүй, газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй газар эзэмшигч, ашиглагч нарын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч, төлбөрийг барагдуулах чиглэлээр шүүхийн байгууллагад шилжүүлэхээр бэлтгэж байна. 5 сарын байдлаар газрын төлбөр 193945,7 сая төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлээд байна.	
92	3.1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг сумдад зохион байгуулна.	1. Эрсдэл өндөртэй төсөвт байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалт, үзлэг зохион байгуулах	2021 - 2024		9	Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн үзлэгийг 2023 онд Гурванбулаг, Эрдэнэцогт, Хүрээмарал, Заг сумдад хийхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилийн байдлаар Хүрээмарал, Заг сумдын төсөвт байгууллагуудын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэлээ. Хүрээмарал сумд нийт 140,673,947 төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч Улсын ахлах байцаагчийн 3,319,670 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 105,193,186 төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 32,161,091 төгрөгийн зөвлөмжийг бичиж хүргүүлсэн. Заг сумд нийт 164,254,198 төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч Улсын ахлах байцаагчийн 19,679,249 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 17,413,000 төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 127,161,949 төгрөгийн зөвлөмжийг хүргүүлэн зөвлөн туслаж ажилласан.	
93		2. Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг байгууллага тус бүр дээр	2021 - 2024		3	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн аймгийн засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитээр шууд захирагчийн 11 байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 6 байгууллага Хязгаарлалттай дүгнэлт авсан, Үүнээс Баянцагаан ЗДТГ, Богд ЗДТГ, Жаргалант ЗДТГ, Баян-Өндөр ЗДТГ, Бөмбөгөр ЗДТГ, Баян-	

		хэлэлцүүлж, залруулах арга хэмжээ авах				овоо ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга нартай уулзаж аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг сум бүрээр хэлэлцсэн, цаашид шууд захирагчийн 11 байгууллагад хариуцлага тооцох санал хүргэхээр төлөвлөж байна	
94	3.1.3. Хуримтлалтай хонгорчууд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1. Хуримтлалын бүлгийг нэмэгдүүлэх	2021 - 2024		138	Тус аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хуримтлалын 125 бүлэг байгаа бөгөөд нэг бүлэг 1 жилд 5 саяас 30 сая төгрөгийг хуримтлуулж, ноогдол болгон хуваан авч байна. Нийт хуримтлуулсан мөнгөний 60% нь зээлд гарсан байна. Зээлийг Бизнес, Эрүүл мэнд, Боловсрол, Өдөр тутмын ахуйн хэрэгцээндээ зориулж авсан байна. Тус оны төсөвт санхүүжилт тусгаагүй болон COVID-19 цар тахалтай холбоотойгоор Бүх нийтийн бэлэн байдал зарлаж, сургалт уулзалтууд цуцлагдсан тул бүлгийн сургалт зохион байгуулаагүй боловч өмнө үүсгэсэн бүлгүүдэд заавар зөвлөгөө өгч үйл ажиллагаа хэвийн явж байна. Өнгөрсөн онд хуримтлалын бүлгүүдийн төлөөлөл 315 хүнийг хамруулсан зөвлөгөөн болон спортын тэмцээнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр "Хуримтлалтай Хонгорчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд гишүүдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулах, дотоод дүрэм журам боловсруулах ажлууд хийгдлээ. Энэ онд 3 бүлгийг шинээр зохион байгууллаа. Хуучин бүлгүүдийн судалгааг цуглуулж мэдээллийн сантай болсон.	
95		2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд санхүүгийн мэдлэг олгох	2021 - 2024		6	"Жижиг мөнгөн тэмдэгийг хэн сайн цуглуулах вэ" уралдааныг хүүхдүүдийн дунд 8 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж 1-т, 5-т, 10-т, 20-тийн дэвсгэртийг нийт 73 хүүхэд 65331 ширхэг дэвсгэрт цуглуулсан, мөнгөө арилжааны банканд өгч сайн тэмдэгтээр солиулж авлаа. Хамгийн олон дэвсгэрт цуглуулсан эхний 3 хүүхдэд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр шагналыг нь гардуулан өгсөн. Хүүхдүүдийг мөнгөн тэмдэгт зөв боловсон харьцах, цуглуулж хуримтлуулах дадал хэвшилд сургасан сайхан үйл ажиллагаа болж өндөрлөлөө.	

96	3.1.4. Тунгалаг санхүү	1. “Жишиг санхүүгийн алба” үзүүлэх сургалт” зохион байгуулах	2021 - 2024		14	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн цахим шилжилтийн бодлого, зорилтын хүрээнд улс орон даяар 2023 оноос эхлэн төрийн сангийн нэгжүүдээр хийгдэх төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог "Төрийн сангийн удирдлагын цахим систем" буюу шинэ цахим системд бүрэн шилжүүлсэн. Сумдын санхүүгийн албаны төлбөр тооцоо шинэ системд шилжсэнтэй холбоотойгоор 2023 онд "Жишиг санхүүгийн алба" үзүүлэх сургуулийг сумдад зохион байгуулаагүй. Үүний оронд аймгийн төрийн сан дээр шинэ төлбөр тооцооны системийн сургалт, зөвлөгөө, дадлага ажлыг 2023 оны 5 дугаар сарын 18,19-ны өдрүүдэд хийсэн. Төрийн сангийн төлбөр тооцооны цахим шинэчлэл ажлын хүрээнд сумдын санхүүгийн албадын дунд "Шилдэг цахим санхүүгийн алба уралдааныг аймгийн Засаг даргын 2023 оны А/31 дүгээр захирамжаар батлуулан, амжилттай зохион байгуулсан.	
97	хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх	2021 - 2024		83	Шинээр 2022 онд 209 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдэж нийт тайлан ирүүлэх 1638 аж ахуйн нэгж байгууллагаас 276 аж ахуйн нэгж, байгууллага тайлан ирүүлээгүй, 1362 аж ахуйн нэгж, байгууллага тайлан ирүүлж, тайлангийн ирц 83 хувьтай байна.	
98		3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх	2021 - 2024		53	Нягтлан бодох бүртгэлийн аймгийн үзлэгийн хүрээнд жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программын судалгааг шинэчлэсэн	

99	3.1.5. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулна.	1. Төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалттай холбоотой зөрчлийг арилгах	2021 - 2024		3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд татан төвлөрүүлэх нийт 78 тээврийн хэрэгсэл байгаагаас 40 тээврийн хэрэгсэл татан төвлөрүүлсэн, 11 тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлсэн, 6 тээврийн хэрэгсэл акталсан, 13 тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж орон нутгийн төсөвт 214 сая төгрөгийг төвлөрүүлсэн. 2023 оны хагас жилийн байдлаар 17 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулж, балансаас балансад шилжүүлсэн болон худалдсан, шинээр худалдан авсан тээврийн хэрэгсэлүүдийг холбогдох байгууллага болон хувь хүний нэр дээр гэрчилгээг шилжүүлсэн. Нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан 13 тээврийн хэрэгслийн татвар, торгуулийг төлүүлэхээр тухайн байгууллагуудад хүргүүлсэн. Орон нутгийн өмчит байгууллагуудын нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг Авто тээврийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй тулган шалгахгаар авто тээврийн төвд хүсэлт явуулсан.	
100		2. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, коджуулах	2021 - 2024		15	Энэ оны хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 144 байгууллагын 35,4 тэрбум төгрөгийн өмч хөрөнгөтэй холбоотой Аймгийн ИТХ-ын Хуралдааны тогтоол шийдвэр гарсан. Үүнээс: Орон нутгийн өмчит 96 байгууллагын 29,2 тэрбум төгрөгийн хөрөнгөнд эзэмшигч тогтоох, 48 байгууллагын 4,6 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах, 6 байгууллагын 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 15 байгууллагын 0,5 тэрбум төгрөгийн хөрөнгийг худалдах тухай тогтоол шийдвэр гарч холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Ашиглалтгүй байсан Аймгийн “Чандмань Баянхонгор” ХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Хонгор 1000” дулаан үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хувьчилж 2,0 тэрбум төгрөгөөр “Зүүн Шанд” ХХК шалгарсан. Мөн Баянхонгор Төхижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй зам талбайн хавтан үйлдвэрлэлийн барилга, байгууламж, иж бүрэн автомат тоног төхөөрөмжийг худалдах доод үнэ 385 сая төгрөгөөр хувьчлах уралдаант сонгон шалгаруулалтын зарыг нийтэд зарласан.	

101	3.2.1. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхижүүлж оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.	1. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх санал хүргүүлэх, уулзалт зохион байгуулах	2021 - 2024		1	Аймгийн хэмжээнд Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төсөл, НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр “Утаагүй Баянхонгор” төсөл, НҮБ-ын Хүүхдийн сан, БНСУ-ын “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл, Франц улсын санхүүжилтээр Тогтвортой ноолуур төсөл, Европын Холбооны санхүүжилтээр Бүгд Залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө, Best хөтөлбөр, Дэлхийн банкны санхүүжилтээр Тогтвортой Амьжиргаа-3 төсөл, Монголын Улаан Загалмайн нийгэмлэг, НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр “Хүүхэд эсэн мэнд амьдрахуй” төсөл, Монгол улс дахь Австралийн Элчин сайдын яамтай хамтран “Малчдын эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ” төслүүдийг тус тус амжилттай хэрэгжүүлэв.	
102	3.3.1. Орон нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй байгуулах гэрээнд төр, иргэдийн оролцоог хангаж ажиллана.	1. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн гэрээний хэрэгжилтийг хангуулах	2021 - 2024		70	Тус аймагт 2022 онд 14 аж ахуйн нэгж ашиглалтын үйл ажиллагаа явуулснаас 12 аж ахуйн нэгж аймгийн Засаг даргатай, 2 аж ахуйн нэгж холбогдох сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Үүнээс хагас жилийн байдлаар 5 аж ахуйн нэгж дунджаар 93 хувьтай гэрээний биелэлтийг дүгнүүлсэн.	
103	3.3.2. "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд	1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах	2021 - 2024		8	Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Өлзийт, Гурванбулаг сумдад "Хариуцлагатай уул уурхай-Эдийн Засгийн үндэс" сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	

	зохион байгуулна.					
104	3.3.3. "Баялагийн сан" байгуулж, олон нийтийн хяналтан дор байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн шинжтэй төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ.	1. Баялагын сан байгуулж, төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх	2021 - 2024		20	Төсвийн тухай хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдэл хэсэг болгосонтой холбогдуулан Баялагын сан байгуулах боломжгүй болсон.
105	3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах.	2021 - 2024		25	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар "ХАМОДХ "ТББ-ийн 17 нөхөрлөлийн 153 хүн, "Стархолдинг" ХХК-ний талбайд ажиллах 6 нөхөрлөлийн 54 иргэн нийт 207 иргэнд бичил уурхайгаар үйл ажиллагаа эрхлэх журам, үйл ажиллагаа явуулах ажлын чиг үүрэг бусад мэдээ мэдээллийг өгч бичиг баримтын бүрдэл гэрээний хэрэгжилтийг шалган зөвлөн туслах үйлчилгээг 2 удаа үзүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар хамтран тус аймагт бүртгэлтэй нөхөрлөлийн ахлагч, гишүүд бүхий 90 гаруй хүнд Засгийн газрын 296 дугаар тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилт, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч, иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэсэн.
106		2. Бичил уурхай эрхлэгчдийг хууль тогтоомжийн дагуу	2021 - 2023		2	Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журам батлагдаж бичил уурхай эрхлэгчид хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа эрхлэх

		үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, хяналт тавих				боломжтой болсон. Энэ онд Байгаль орчин, аялал жуулчлалын газраас нийт 97 зөрчил дээр холбогдох арга хэмжээг тооцож ажилласан. Нийт зөрлөөс хэргээс татгалзаж шийдвэрлэсэн 7, Хялбаршуулсан журмаар 150,000 төгрөг, 13,500,000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг ногдуулж хүү торгуулийн мөнгийг төрийн сангийн дансанд бүрэн төлүүлж барагдуулсан.	
107	3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах	2021 - 2024		15	Эвдэрсэн газрын 2021 оны тооллогоор аймгийн хэмжээнд нийт 13 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 21 багийн 120 нэгж талбарт 586,74 га талбай эвдрэлд орсон. Үүнээс уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2021 онд 102,4 га, 2022 онд 77.87 га талбай нийт 180,27 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Германы хөрөнгө оруулалтаар 120 га талбайд, аж ахуйн нэгжүүдийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 80 га талбайд нийт 200 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар эвдэрсэн газрын хяналтын тооллого хийх ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 10-24-ны хооронд хяналтын тооллогыг зохион байгуулна.	
108	3.4.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг бий болгоно.	1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах	2021 - 2024		70	Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулахаар ажиллаж байна. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилгын ажлыг 2021 онд тендер сонгон шалгаруулалт зарлан “Базарь дарь” ХХК шалгаран барьж 2022 онд үйлдвэрийн барилгыг хүлээлгэн өгсөн. Цаашид тус үйлдвэрийн үйл ажиллагааг Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ газар хариуцан ажиллах юм. Тус төслийн нийт төсөв 3,8 тэрбум. Мах ногооны зоорь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж Сант-Өндөр ХХК шалгарч барилгын ажлыг	

					<p>эхлүүлж, 2021 онд 250 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2022 онд санхүүжилт олгогдоогүй. Тус мах, ногооны зорь 2024 онд ашиглалтад орно. Хөдөө аж ахуйн цогцолборын үйлдвэрлэлийн бүсийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажилд “Алтай эколос” ХХК, цахилгааны эх үүсвэрийн материал нийлүүлэх ажилд “Эн ди эм эм” ХХК, гадна холбооны шугамын материал нийлүүлэх ажилд “Нью Бест хаус” ХХК тус тус шалгарч дээрхи ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. 2022 онд 850 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон. 2023 онд 823.7 сая төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс авсан байна.</p>	
109	3.4.2. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.	1. Хөдөө аж ахуйн загвар хоршоо байгуулах	2022 - 2024	1	<p>Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хоршоог дэмжих жил”-ийн хүрээнд хоршоологчдын аймгийн зөвлөгөөнийг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн хүүхдийн Тэмүжин театрт зохион байгууллаа. Баянхонгор аймгийн ХАА-н хоршоологчидтой уулзаж төрөөс хоршооны талаар баримталж буй бодлогыг сурталчлах, төр хоршооллын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоршоод хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, тогтвортой хөдөө аж ахуй эрхэлсэнээр хоршооны гишүүд, малчдын амьдрал, хүрээлэн буй орчинд гарах өөрчлөлтийг таниулах, хоршоодыг идэвхжүүлэхэд зөвлөгөөний зорилго оршив. Зөвлөгөөнд 20 сумын Засаг дарга нар, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд, сум бүрээс хоршоодын 1-3 төлөөлөл, бусад төслийн байгууллагын оролцогчид нийлсэн 120 гаруй хүн зөвлөлдлөө. Зөвлөгөөнд төрийн бодлого шийдвэр, цаашид авах арга хэмжээний талаар ХХААХҮЯ-ны ЖДҮГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Э.Гэрэлзаяа, Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбооны ерөнхийлөгч Ц.Алтантуяа, аймгийн ХХААГ-ын дарга Ц.Балжинням, Тогтвортой ноолуур төслийн зохицуулагч А.Лхагвасүрэн, Хөгжлийн шийдэл ТББ-ын бизнесийн зөвлөх Л.Наранбаатар, Төрийн банк зэрэг холбогдох байгууллагаас илтгэл мэдээлэл тавьж, мэдээллээр хангалаа. Загвар хоршоо шалгаруулах хүсэлтийг 11 дүгээр сард ХХААХҮЯ-д уламжилна.</p>	

110	3.5.1. “Бизнес инкубатор”-ийн бодлогыг эрчимжүүлж, гарааны бизнесийг дэмжиж бойжуулна.	1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, бойжуулах	2022 - 2024		30	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр 1.2 тэрбум төгрөг батлагдсан. Төслийн сонгон шалгаруулалтыг хийж, дэд хорооны хурлаар 10 ХХК-ний 1.3 тэрбум төгрөг хүссэн төслийг сонгон шалгаруулах шатандаа ажиллаж байна. Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосноор орон нутагт шинээр 3 үйлдвэр байгуулагдаж, 6 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр 20 гаруй ажлын байр нэмэгдэнэ. Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорациар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нийт 182.0 сая төгрөгийн зээлийг 18 иргэн аж ахуй нэгжид олгосон. 14 ажлын байр хадгалагдаж, шинээр 34 ажлыг бий болгоод байна.	
111	3.5.2. Хүн амын хүнсний хэрэгцээний нөөцийн махыг хувийн хэвшлүүдээр бэлдүүлж дэмжлэг олгоно.	1. Махны нөөцийг бүрдүүлж, үнийг тогтворжуулах	2021 - 2024		200	Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 180тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгж нь Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжын дагуу хийж байна. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2023 оны 04 дүгээр сарын 04-өөс 06 дугаар сарын сарын 04 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 80.0 сая төгрөгийг “Баянхонгор констракшн” ХХК-д олгох бөгөөд гэрээний дагуу 40.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	
112	3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг	1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон	2021 - 2024		70	2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 сумын 10418 толгой бод, бог, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4773 бог малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж, үзлэг ангилалтанд хамруулсан бөгөөд ашиг шимийн түвшин стандартын босго үзүүлэлтийг бүрэн хангасан. 2022 онд бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад байлгах зорилгоор 20 сумын	

	нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ.	үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх				бог малын 10.6 мянган хээлтүүлэгчийг 86 суурьт ялган төвлөрүүлсэн. Бог малын хээлтүүлэгчийг хавар намрын үзлэг ангилалтад 20 сумын 14.1 мянган малыг хамруулсан. Эрдэнэцогт сум ОНХС-ын хөрөнгөөр 648 сарлагт үзлэг ангилалт хийсэн. Сүргийн бүтцэд хонин сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацыг сайжруулах, сүргийн чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Баянцагаан сумын цөм сүргийн нэгж Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авсан. AVSF төсөл хэрэгжиж буй 7 сумын 7 хоршоонд малын чанар сайжруулах чиглэлээр Залаа жинст-Эдрэн үүлдэр, Бөмбөгөрийн улаан омгийн 200 эм ямаа, 20 ухныг 45,0 сая төгрөгийн буцалтгүй хөрөнгө оруулалтаар нийлүүлж, сүргийн бүтцийг сайжруулсан. Бог малын хээлтүүлэгчийг хавар, намрын үзлэг ангилалтад 20 сумын 14.1 мянган малыг хамруулсан. 2023 оны хаврын үзлэг ангилалтаар Ламын гэгээний улаан үржлийн хэсгийн тэмээ 200 толгой, Залаажинст-Эдрэн үүлдрийн 354 ямаа, Бөмбөгөрийн улаан омгийн 531 ямаанд үзлэг ангилалт хийгдсэн. Мөн Баянбулаг омгийн 900 хонинд хийгдсэн. Малын чанар сайжруулах ” Шинэ хөдөө хөдөө” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг омгийн өсвөр хээлтүүлэгч-500, хээлтэгч-400, Сэлэнгэ үүлдрийн Бухан бяруу-20 үржлийн хээлтэгч -43, Сарлагын бухан бяруу-6 олгосоныг сумдад хүлээлгэн өглөө. Баталгаажсан үүлдэр омгийн цөм сүргийн малын тоо 87.8 мянган толгой байна.	
113		2. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хяналтад ялган төвлөрүүлэх	2021 - 2024		70	Аймгийн хэмжээнд өнгөрсөн 2022 онд мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний 11 нэгж тоологдсон бөгөөд энэ онд “Мандаа торгон сүрэг” ХХК шинээр нэмэгдэн 12 аж ахуйн нэгж бүртгэгдсэн. Нийт 20 сумын 43 багийн 52 суурьт хуц 4149, ухна 5164 бүгд 9313 буюу нийт хээлтүүлэгчийн 61.5 хувийг ялган төвлөрүүлсэн.	
114		3. Малчдын мэдлэг, мэдээллийг	2022 -		100	2021-2022 онд сумын Засаг даргын тамгын газар, Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан 20 сумын давхардсан тоогоор 5858 малчинд	

		нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	2024			салбарын болон цаг үеийн мэдээлэлээр сургалт хүргэж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Мөн 9,10,11,12 дугаар ангийн 890 гаруй сурагчдад малын эмч мэргэжил болон зорилгодоо хэрхэн хүрэх, талаар сургалтыг амжилттай зохион байгуулж энэ чиглэлийн мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэж байна.	
115		1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах	2021 - 2024		2	2021-2023 онд орон нутагт зонхилон гардаг мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 4.5 сая толгой малыг хамруулсан байна. Мөн Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх масс дархлаажуулалтад нийт 1.8 сая толгой мал, амьтныг хамруулсан. Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулснаар мал, амьтны гоц халдварт өвчингүй, ногоон бүс болсон. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 20 сумын 5,9 сая толгой малыг хамруулаад байна.	
116	3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана.	2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих	2021 - 2024		7000	2021-2023 онд мал эмнэлгийн нэгдсэн системд малчид, мал бүхий иргэдийн хүсэлтээр нийт 19295 гарал үүслийн гэрчилгээ баталгаажуулж үүнээс 2023 оны эхний хагас жилийн байдлаар 874 гэрчилгээ баталгаажуулж ажилласан. Уг системээр дамжуулан мал, малын гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлт, шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл болон малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавьж ажиллаж байна.	
117		3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас	2021 - 2024		15	2021-2022 онд гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор аймгийн Онцгой комиссоос ариутгалын бодис 1,0 тн, Халдвар хамгаалалтын хувцас 1000ш, амны хаалт 5000ш, бээлий 100ш, Нүдний шил 1000ш, Улавч 1000 ширхгийг тус тус олгож нөөц бүрдүүлсэн ба Мал эмнэлгийн тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулалтын дагуу ашигласан. 2023 онд гамшгийн бэлэн байдалд	

		хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх				хэрэглэх мал эмнэлгийн халдваргүйтгэлийн бодис 500 кг, халдвар хамгаалалтын хувцас 250 ш, бээлий 5000 ш, маск 3260 ш, Нүдний шил 1000 ш нөөц бүрдүүлж ажилласан.	
118	3.6.3. Бэлчээр менежментийг сайжруулах зорилгоор шаардлагатай цэгүүдэд уст цэг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулна.	1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх	2021 - 2024		5	2021-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр 1, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 10, гадаадын төсөл хөтөлбөрөөр 1, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6, сумдын малчид өөрсдийн санаачилгаар 4 сум нийт 39 худаг шинээр гаргаж, засварласан нь 42.0 мянган га талбай бэлчээрийг усжуулж, 100 гаруй өрхийн 108,0 мянган толгой мал, амьтан усаар хангагдлаа. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр уст цэгийн хайгуулыг Баян-Өндөр, Шинэжинст сумдууд 17 цэгт хийсэн. 2023 онд улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Богд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баацагаан, Богд, Гурванбулаг, Өлзийт сумын нутагт гүн өмрийн 4 худаг шинээр буюу сэргээн засварлахаар гүйцэтгэгч аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.	
119		2. Аймгийн хэмжээнд дэвшилтэт аргаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх	2021 - 2024		20	2021 онд бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зорилгоор улсын болон аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бактержуулсан бэлдмэл авч нийт 50 тн бэлдмэлийг Өлзийт, Эрдэнэцогт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Баян-Овоо, Галуут сумдын 46 мянган га-д бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг гүйцэтгэн техникийн үр дүнг 90% буюу “үр дүнгтэй” дүгнүүлсэн. Мөн Улсын төсвийн хөрөнгө 80,0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгчтэй энгийн механик аргаар тэмцэх ажлыг Гурванбулаг, Баянбулаг, Бөмбөгөр, Жаргалант, Заг сумдын 31,5 мянган га талбайд гүйцэтгэсэн. 2023 Аймгийн хэмжээнд бэлчээрийн хортон мэрэгч ихээр тархсан хангайн 11 сумын 30.0 мянган га талбайд 35 тн бактержуулсан бэлдмэлийг цацаж бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулан ажлын үр дүнг 85 хувьтай дүгнүүлээ.	

120	3.6.4. Аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэнэ.	1. Аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг зохих түвшинд бэлтгэх	2021 - 2024		200 , 50	2021 онд аймгийн аюулгүйн нөөцөд 120 тн ногоон тэжээл, 35 тн хорголжин тэжээл, 2022 онд аймгийн аюулгүйн нөөцөд 300 тн өвс, 95 тн хорголжин, улаан хивэг тус тус бэлтгэн эрсдэлээс сэргийлж ажилласан. 2023 оны нөөц бүрдүүлэлт 10 дугаар сард эхэлнэ.	
121		1. Стандартын шаардлага хангасан 1000тн-ы төмс, хүнсний ногоо, махны зоорьтой болох	2021 - 2023		100	Агро парк байгуулах ажлын хүрээнд 1000 тн-ны багтаамж бүхий мах, ногооны зоорь, бойны газар байгуулах зураг, төсвийг “Мандала арт” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Мах ногооны зоорь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендерт “Сант-Өндөр” ХХК шалгарч барилгын ажлыг эхлүүлсэн. 2021 онд 250 сая төгрөгийн санхүүжилт олгогосон ба 2023 онд бүрэн дуусч ашиглалтад орно.	
122	3.6.5. Техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг өсгөнө.	2. Тариалалтад ашиглах техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, дундын үйлчилгээний нэгж байгуулах	2022 - 2024		70	2021 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын дэмжлэгээр 32 м2-ийн 5 ширхэг хүлэмж, төмс хүнсний ногооны иж бүрэн мотоболок, төмс хураагч зэрэг техник тоног төхөөрөмжийг хүлээн авч Хот тохижилт ОНӨААТҮГ азарт олгосон. 2022 онд Тариалалтад ашиглах техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянхонгор Политехникийн коллежийн 1, ХХААГ-ын 1, Сум дундын ойн ангийн 2, Өлзийт ХААМСҮТ-ийн 1 нийт 5 трактор тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулах боломжийг хангаж хамтран ажилласнаар 23 иргэн, аж ахуй нэгжийн нийт 130 га талбайд хөрс боловсруулалтын ажлыг хөнгөлөлттэй үнээр хийж дундын үйлчилгээг үзүүлсэн байна.	
123		3. Хүнсний нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өвөл, зуны хүлэмжийн парк аж ахуй бий	2021 - 2024		25 , 0	2022-2023 онд өвөл зуны хүлэмж, зоорь агуулахыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хүлэмжийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулснаар 55.5 сая төгрөгийн үнэ бүхий 42 хүлэмжийг 40 гаруй иргэд, аж ахуй нэгж өөрсдийн хөрөнгөөр худалдан авч, компанийн зүгээс 3.5 сая төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг услалтын системийг үнэ төлбөргүйгээр олгосон. Мөн ЖДҮХ сангаас Баянхонгор сумд өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах 2 төсөлд, ОНТөсвийн	

		болгох				санхүүжилтээр 3 иргэнд хүлэмжийн аж ахуйн төсөл, Хоршоог хөгжүүлэх сангийн 87.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 300 м2-ийн 2 өвлийн хүлэмж байгуулах төслийг тус тус олгож дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд 2022 онд 612 м2 талбай бүхий 3 өвлийн хүлэмж, 9536.2 м2 талбай бүхий нийлэг хальсан 152 хүлэмж үйл ажиллагаа явуулж 78.1 тн ургац хураан авсан байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмжийн цогцолбор барьж байгуулах төслийг хэрэгжүүлэн тендер зарлан "Номгоны андууд" ХХК шалгарч 60 ширхэг 6*10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмжийг нийлүүлсэн. Хөрс боловсруулалтын ажлыг бүрэн хийж тариалах иргэдийг Баянхонгор сумын 10 багаас сонгон шалгаруулж гэрээ байгуулан ашиглуулахаар шийдвэрлэсэн. Шинэ хөдөө төслийн хүрээнд ХХААХҮЯ-наас 6*10 хэмжээтэй 21, 4*8 хэмжээтэй 21 нийт 42 ширхэг хүлэмжийг нийлүүлсэн бөгөөд тус хүлэмжийн цогцолборт хамтад нь барьж нийт 100 хүлэмж бүхий агропаркийг байгуулах ажил хийгдэж байна. Ногоон шим төслийн хүрээнд тус бүр нь 1000 м.кв 2 ш өвлийн хүлэмжийн барилгын ажил 30 хувьтай явагдаж байна. Мөн БНХАУ-Гансу мужтай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус бүр нь 800 м.кв 2 ш өвлийн хүлэмжийг барьж ашиглалтад оруулах ажлын эхлэл тавигдаж 06 дугаар сарын 06-12-ны өдрүүдэд манай аймагт ажиллаж, хөрс цаг уурын нөхцөл дээр үндэслэн гүйцэтгэл явагдахаар байна.	
124	3.7.1. Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	1. Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах	2021 - 2024		5 , 6000	Жинст суманд 2023 оны 02 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд "Тэмээний баяр", Баянхонгор суманд 2023 оны 02 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд "Түйн голын жавар-2023" арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Тэмээний баярт 4 аймгийн 350 гаруй тэмээчид оролцсон. Түйн голын жавар мөсний баярт төрийн 28 байгууллага, хувийн хэвшил 25, нийт 53 байгууллагын 1100 албан хаагч, 28 гэр отго барьж оролцсон төдийгүй сумын иргэд, жуулчид давхардсан тоогоор нийт 5000 орчим хүн оролцсон.	
125		2. Аялал жуулчлалын видео	2021 -		15 ,	Видео контентийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хугацаа	

		контент нэвтрүүлэг бэлтгэх	2023		150000	болоогүй.	
126		3. Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын тохижилтийг үе шаттайгаар хийж гүйцэтгэх	2021 - 2024		1	Улсын болон орон нутгийн төсөвт төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг тохижуулах төсөв тусгагдаагүй. Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлж буй төсөлд Ихбогд уулын Цонж, Улиатай аманд тохижилт хийхээр 30,0 сая төгрөгийн төсөл бичиж хүргүүлсэн ба төсөл сонгон шалгаруулалтын шатанд байна.	
127	3.8.1. Аймгийн төв доторх шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам, явган зам, унадаг дугуйн зам барих, нөхөх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол, тэмдэг тэмдэглэгээ хийж автозамын аюулгүй байдлыг хангана.	1. Шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам шинээр барих, нөхөөс хийх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол хийх	2021 - 2023		0.2, 1000м, 2	2021 онд Аймгийн замын сангийн 46,0 сая төгрөгийн хөрөнгөөр 880 м2 хатуу хучилттай автозамын нөхөөс, 514,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Есөн эрдэнэ” захын баруун талаас Хонгор хотхоны ар тал хүртэлх 1.2 км замын барилгын ажил, түүнчлэн Эрдэнэцогт-Баянхонгор чиглэлийн 1,7км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг тус тус гүйцэтгэсэн. Мөн Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төсвийг хийлгэсэн. 2022 онд 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тухайн онд 1.5 тэрбум төгрөгөөр санхүүжих 15 төсөл арга хэмжээг бүрэн хийж гүйцэтгэсэн. Тухайлбал 1,2 км зам дагуу явган хүний зам, аймгийн төв доторх 1800м2 талбайн нөхөөс, аймгийн төв доторх 1,65 км авто зам, 55 машины авто зогсоол, сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах, аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах, аймгийн төв доторх асфальтан хучилттай 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлт хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2023 онд аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх ажлыг Замын сангийн 80,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхэр гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендэрийг зарласан. Эрдэнэмандал хайрханы өвөрт авто зогсоол байгуулах ажлыг ОНХСангийн 70,0 сая төгрөгөөр “Унага трейд” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгхөд бэлэн болоод байна.	

128		2. Аймгийн төв доторх хатуу хучилттай зам дагуу явган зам, унадаг дугуйн зам барих, шинэчлэх	2021 - 2023		1.2 ,0.0	<p>2021 онд зам дагуух явган замын ажлыг хэмжээтэй хийж гүйцэтгэсэн. Мөн Оготнотой булгийн зам дагуу 600м талбайд унадаг дугуйн зам барьж ашиглалтад оруулсан. 2022 онд Эрүүл мэндийн газрын хойд гэрлэн дохионы уулзвараас аймгийн Засаг даргын Тамгын газар хүртэл 697,8 м2 явган зам, Угалз багийн нийтийн орон сууцны 200 дугаар байрны хойд тал, замын зүүн талаар 139,5 м2 явган зам, 200 дугаар байрнаас Оготнотой булаг хүртэлх замын урд талаар 633,15м2 дугуйн болон явган зам, Хүнс, хөдөө аж ахуйн газрын замын 2 талаар 2100м2 явган зам, “Цэлмэг өглөө” захаас 4 дүгээр цэцэрлэг хүртэл- 900, “Чандмань – Баянхонгор” ХК-с Шөнийн зах хүртэл- 600, “Их богд” авто засвараас “Мэргэжлийн хяналтын газар” хүртэл-700, “Мал эмнэлэг”-ээс Модерингийн уулзвар хүртэл- 1500, Баянхонгор их дэлгүүрээс хүүхдийн Тэмүүжин театр хүртэл- 500 нийт 4200м2 талбайд явган зам барьж ашиглалтад оруулсан. Тоосжилт бууруулах чиглэлээр орон сууцны болон төв зам дагуух шороон хөрсийг эко хавтангаар хучилт хийх ажлыг эхлүүлж “Хаш шоо” -1070, “Голомт банк”-1000, “Эрдэнэт хивс”-530, “Жаргалант парк” баруун тал-3500 нийт 6370м2 талбайд тус тус хийж тоосжилтыг бууруулсан. 2023 онд замын сангийн 220,0 сая төгрөгөөр Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам хийх ажлыг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалт зарлаж шалгарсан аж ахуй нэгж болох “Тэнгэрийн уул” ХХК-тай, мөн энэ чиглэлд дугуйн зам хийх ажлыг замын сангийн 220,0 сая төгрөгөөр гүйцэгэхээр "Унага трейд" ХХК-тай тус тус гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Соого сейко сургуулийн арын уулзвараас арван мянгатын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх ажлыг замын сангийн 240,0 сая төгрөгөөр хийхээр шалгарсан “Буян ариажих од” ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Баянхонгор сумын шаардлагатай газруудад явган хүний зам байгуулах ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласан боловч аж ахуй нэгж шалгараагүй байна.</p>	
-----	--	--	-------------	--	----------	---	--

129		3. Замын хөдөлгөөн зохион байгуулах хурд сааруулагч, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио хийх	2021 - 2023		16, 2000 , 4	2021 онд Замын сангийн 21,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Хурд сааруулагч” нийт 16 ширхэг, 50сая төгрөгийн хөрөнгөөр 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээ, 90 сая төгрөгийн хөрөнгөөр 1800 м2 талбайд замын нөхөөс, 163,0 сая төгрөгийн хөрөнгөөр арван мянгатын 1,2 км авто зам дагуух явган хүний зам барих босоо бордюр, 515,2 сая төгрөгийн хөрөнгөөр Есөн-Эрдэнэ захаас Хонгор хотхон хүртэлх 1,2км хатуу хучилттай замд хучилт, 499,7 сая төгрөгийн хөрөнгөөр Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвараас аюулгүйн тойрог хүртэлх 900м хатуу хучилттай авто замын шинэчлэл, 451 сая төгрөгийн хөрөнгөөр Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын уулзвар хүртэлх 750 м талбайд хатуу хучилттай авто зам барих, 40 сая төгрөгийн хөрөнгөөр Оготнотой булаг орчмын тоглоомын талбайн 55 машины зогсоолын газар шорооны ажил, 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэмандал сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах зэрэг ажлыг тус тус гүйцэтгэсэн. 2023 онд аймгийн төвд стандартын шаардлага хангасан хурд сааруулагч байршуулах ажлыг Замын сангийн 20,0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "БМБЖБ" ХХК-тай, Номундалай цогцолбор, 5-р сургууль болон Номгон сургуулиудын сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулахаар гүйцэтгэгч компаниуд, Хөгжимт драмын театрын явган хүний гарцыг стандартын дагуу тохижуулах ажлыг замын сангийн 20,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Мандай групп" ХХК-тай тус тус гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн	
130	3.8.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор томоохон голуудад төмөр бетонон гүүр барина.	1. Томоохон голуудад төмөр бетонон гүүр барих	2021 - 2024		3	2021 онд Галуут сумын Мандалын голын 62 у/м төмөр бетон гүүрийн ажлыг “ Эвт уул” ХХК , Галуут сумын Өлзийт голын төмөр бетон гүүрийн ажлыг “Их богд зам “ ХХК тус тус гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан. Загийн голын 90.9у/м төмөр бетон гүүр болон Богд сумын Түйн гол дээгүүр төмөр бетонон гүүр барих ажлын зураг төсвийг шинэчлэн боловсруулж 2023 оны улсын төсөвт тусгах санал явуулсан болно.	

131	3.8.4. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ.	1. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэх	2021 - 2024		2	"Aeromongolia" ХХК нь 2021 оны байдлаар долоо хоногт 1 удаа нислэг үйлддэг байсан ба Улаанбаатар-Баянхонгор, Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 24 нислэг үйлдсэн. Нисэх буудлын хэмжээнд нийт 54 нислэг хийсэн байна. Коронавирусын цар тахал болон нисэх буудлын барилгын засвартай холбоотойгоор 2021 оны 6-р сард нислэгийн үйл ажиллагааг зогсоосон. 2022 онд шатахууны нэмэгдэлтэй холбоотойгоор нислэг хийгээгүй. Энэ оны байдлаар 2023 оны 5-р сарын 24-ний ЗГ-ын хуралдаанаар Засгийн газрын Баруун таван аймгийн чиглэлд нислэгийн үйл ажиллагааг сэргээх тогтоол гарсан. Нислэгийн тов хараахан гараагүй.	
132	3.9.1. Төвлөрсөн хот сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг сайжруулна.	1. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станц барьж, ашиглалтад оруулах	2021 - 2024		50	Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хот суурин газрын дулаан хангамжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн төвд дулааны станц, шугам сүлжээ барих төслийг 148,0 сая долларын зээлээр хэрэгжүүлэх болсон. ТЭЗҮ боловсруулалтын ажил хийгдэж дууссан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан Инженеринг” ХХК, туслан гүйцэтгэгчээр “МЭЗ” ХХК гэрээ байгуулсан. 2022 онд барилгын суурийн ажил дууссан ба хөрс нягтруулалт, шороо булалтын ажил хийгдсэн. Энэ онд барилгын угсралтын ажлыг 2023 оны 04 дүгээр сард эхлүүлээд байна. Мөн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээний ажлын улаан шугамыг тавиад байна. Ажлын явц 30%-тай үргэлжилж байна.	
133		2. Баянхонгор аймгийн төвийн 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээг шинэчлэх	2023 - 2024		50	Баянхонгор сумын дулааны 2-р хэлхээний шугам сүлжээний ажлын зурагт төслийг 2020 оны хийлгэж батлуулсан бөгөөд 2023 оны Улсын төсөвт суулгуулхаар санал хүргүүлсэн боловч шийдэгдээгүй байна	

134		3. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх	2021 - 2023		100	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажилд улсын төсвийн 7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 2022 оны 1-р сарын 28-ны өдөр Тендер сонгон шалгаруулалт зарлагдаж “Гал хонгор” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. 2022 онд 480 сая төгрөг батлагдаж шинээр баригдсан Ингэний сүүний үйлдвэр, мах ногооны зоорийн барилгад дулаан хангамж болон цэвэр усны 230м шугам хоолойн угсралтын ажил хийгдсэн. Энэ оны угсралтын ажлыг эхлүүлэхээр Зураг төслийн зохиогч ДНТ ХХК-тай шугам сүлжээний трасс зөвшилцөх ажлыг зохион байгуулсан. Инженерийн шугам сүлжээний угсралтын ажил гадна бохирын шугам сүлжээ угсралтын ажлыг эхлүүлээд байна.	
135		4. Залуус хороололд инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх	2022 - 2024		30	Залуус амины орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг)-ийн ажлын зургийг “ДНТ” ХХК гүйцэтгэн 2022 онд хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг "Б софт" ХХК 2022 онд ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд Залуус хороололд дулаан цэвэр, бохир усны шугам ажлууд хийгдэхээр ажиллаж байна.	
136	3.9.2. Зарим сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. "Сумын төвийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх	2021 - 2023		2	Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Бридж бюлдинг” ХХК гэрээ байгуулж 2021 онд ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд 60-70 м3 хүчин чадалтай “Эколос”-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө хийх, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800м урттай дугуйн зам, 2.5 км авто зам, 2.5 км урттай бохирын шугам, Усан хамгамжийн эх үүсвэрийн 25м3 багтаамжтай нөөцийн сав /Хуучин эх үүсвэр ашиглах/, Цэвэрлэх байгууламж ажилуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд хийгдэх бөгөөд шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдсэн. Энэ оны 4 дүгээр улиралд байнгын ашиглалтад оруулна. Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Алегротонер констракшин”	

						ХХК-тай гэрээ байгуулсан. Тус төслийн хүрээнд 2 км авто зам /гэрэлтүүлэг, камер, ногоон байгууламжтай/ 2 км дугуйн зам, 2 км явган зам, Бохирын шугам 2 км, 60м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж, Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, 60м3 багтаамжтай нөөцийн сав, 2км урттай цэвэр болон дулааны шугмын ажлууд хийгдсэн. 100м*70м, 90м*60м талбайтай 2 цэцэрлэгт хүрээлэн, Албан байгууллагуудын ариун цэврийн өрөө шинээр хийх /6 байгууллагын барилгад 12 нойлын өрөө/ ажлууд хийгдэнэ. Тус ажил 2024 оны 3 дугаар улиралд ашиглалтад орно. Баацагаан сумын СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ-ийн сонгон шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зохион байгуулж, "Рино инженеринг" ХХК шалгаран 5 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. Тус ажил нь энэ оны 6 дугаар сард эхлүүлхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	
137		2. Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	2021 - 2024		1	Эрдэнэцогт, Галуут, Баацагаан сумдад 50м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлуудыг тус тус эхлүүлээд байна.	
138	3.9.3. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	1. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2021 - 2024		30	Ус хангамжийн эх үүсвэрт шинээр гүний худаг гаргах ажлыг Засаг даргын нөөц хөрөнгө болон НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр "Баянзаг Дриллинг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлийн бүсийн 9000 метр HDPE маркын хоолойн угсралтын ажил, 500м3 усан сангийн байгуулалтын барилгын болон шугам сүлжээ, тоноглолын угсралт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Шинэ суурьшлийн бүсийн шугам хоолой тоног төхөөрөмжийг "Базардарь" ХХК нийлүүлж, шугам хоолойн угсралтын ажлыг "Чандмань-Баянхонгор" ХК гүйцэтгэн тус тус ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсэд 128м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулж 640 хүүхдийн сургуулийн 100 айлын 2 нийтийн орон сууцны барилга байгууламжийг тус тус	

						холбосон.	
139	3.9.4. Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1. Баянхонгор сумын үерийн далан суваг, борооны болон хөрсний зайлуулах хоолой хийх	2021 - 2024		30	Баянхонгор хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Улсын төсвийн 2023 оны төсвийн төсөлд тус ажлын саналыг хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүй.	
140	3.9.5. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөж, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.	1. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх	2021 - 2024		1	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон Баянхонгор сумын хуунаар 1, 2, 7, 9, 10 дугаар байрнуудыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1840,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022 он тус нийтийн орон сууцны барилгуудыг дахин төлөвлөтөд оруулах ажлуудыг эхлүүлсэн. Баянхонгор сумын 1 дүгээр байрыг “Би ай эм би” ХХК хийж гүйцэтгэн 2023 оны 02 дугаар сард ашиглалтад оруулсан. Үлдсэн 4 нийтийн орон сууцны барилгыг 2023 оны 03 дугаар улиралд багтаан байнгын ашиглалтад оруулхаар ажиллаж байна.	
141	3.9.6. Аймаг, сумдын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй айл өрхийг орон сууцаар хангана.	2. Хонгор-1000 орон сууцны хороолол байгуулах	2022 - 2024		3	Хонгор 1000 орон сууцны хороололд 17 байршил дээр нийтийн орон сууцны зориулалтаар газар олголт хийгдсэн. Мөн Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хонгор 1000 орон сууцны хорооллын талбайг өргөжүүлэн Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулсах тухай АИТХурлын 2022_8/12 Тоот тогтоолоор нийтийн орон сууцны газруудыг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт эзэмшүүлсэн бөгөөд 2022,2023 онуудад төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна.	

142		3. Хувийн хөрөнгө оруулалтаар аймаг болон сумдад нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах	2021 - 2024		250	Энэ онд аймгийн хэмжээнд 1320 айлын 30 орон сууцны барилгын угсралтын ажил явагдаж байгаа бөгөөд 861 айлын 19 орон сууцны барилга ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Эхний хагас жилийн байдлаар 178 айлын 5 орон сууцны барилга ашиглалтад хүлээн авсан.	
143	3.9.7. Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг нэмэгдүүлж, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станцыг шинэчилнэ.	1. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх	2022 - 2024		60	Баянхонгор аймгийн 110/35/6 кВ-ын 12 МВА суурилагдсан чадалтай дэд станцын өргөтгөлийн ажлыг 110/35/10 кВ-ын 36 МВА суурилагдсан чадалтайгаар өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ Трейд" ХХК-тай гэрээ байгуулж ажлыг 2022 онд эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд 5CVG 2ш бүрэн суурьлуулсан. Энэ онд Хаалттай хуваарилах байгууламж, 10кВ-ын 16 МВА суурилагдсан чадалтай трансформаторыг бүрэн суурьлуулж дуусгахаар ажиллаж байна.	
144	3.9.8. Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө.	1. Шаардлагатай сум, багийн үүрэн холбооны 2G, 3G, 4G, 5G сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлэх	2022 - 2023		8	Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 сумын 7 багт үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зарлаад байна.	
145	3.9.9. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан утасгүй сүлжээний дэд бүтэц байгуулна.	1. Утасгүй сүлжээний орчинг бий болгож, төрийн цахим үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэх	2022 - 2024		4 , 4	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх "Ухаалаг Баянхонгор" дэд хөтөлбөрийн инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд Баянхонгор сумын 2, 7, 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт оршин суудаг иргэдэд төрийн үйлчилгээг үнэ төлбөргүй, шуурхай хүргэх, утасгүй интернэтийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд "Бат-Од ХХК" шалгарч "WI-FI" төхөөрөмжийг Эрдэнэмандал хайрхан, жижиг хөх толгой, герман толгой, Дуурсах 3 дугаар багийн 13 дугаар гудамжны үзүүр зэрэг 4 цэгт суурилуулах , программ	

						хангамжийн ажил хийгдсэн. Үлдэгдэл ажлуудаа хийж дуусгаагүй тухайн компанийг шүүхэд өгсөн.	
4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
146	4.1.1. "Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2022 - 2024		44	"Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг боловсруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолоор аймгийн хэмжээний хүний нөөцийн нэгдсэн суурь судалгааг гаргах ажлын хэсгийг томилж, аймгийн хэмжээний 181 төрийн байгууллагын 5079 төрийн албан хаагч судалгаанд хамруулаад байна. Төрийн албаны сонгон шалгаруулалт, ажлын байрны сул орон тооны судалгаа, мэдээлэлд үндэслэн 2023-2026 онд хэрэгжүүлэх "Төрийн мэргэшсэн албан хаагч" хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 181 төрийн байгууллагын 82 нь буюу 45,3 хувь нь байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна	
147	4.2.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна.	1. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга хариуцлагыг	2021 - 2024		120	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна. 1. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга хариуцлагыг чангатгах 2021 - 2024 82 120 Төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор "Хандлага зөвтэй төрийн алба -3" аяныг Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймгийн салбар зөвлөлөөс Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газартай хамтран 6 сарын хугацаатай	

		чангатгах				зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.Тус аяны хүрээнд Баян-Овоо, Богд, Баянцагаан сумдын төрийн албан хаагчидын зөвлөгөөн, сургалтыг зохион байгууллаа. Сумдын ЗДТГ болон 23 агентлагийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.	
148	4.3.1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох.	1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа авах	2021 - 2024		90	Аймгийн хэмжээнд Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангалт, мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын мэргэшүүлэх судалгаанд 40 агентлаг, байгууллагын 265 албан хаагчийн хамруулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Энэхүү судалгаанаас харахад төрийн байгууллагад ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг, тэр тусмаа сумд ажиллах мэдээллийн технологийн мэргэжилтэн олдоогүй нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа сумдад доголддог байна. Улсын хэмжээнд Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академаас зохион байгуулж байгаа Төрийн албан хаагчдын цахим ур чадварын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанд 1124 албан хаагчийг идэвхтэй хамруулав. тус судалгааны нэгдсэн дүнг И-Монгол академ танилцуулна. Судалгааны линк: https://forms.office.com/r/TrveuCXa3d	
149		2. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах	2022 - 2024		50	Цахим хөгжил харилцаа холбооны яамны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын орон нутаг хариуцсан газрын дарга Б.Оргил 05 дугаар сарын 15-нд Баянхонгор аймагт ажиллаж Төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан ажилтан мэргэжилтнүүдтэй албан уулзалт хийж тус уулзалтын үеэр Цахим хөгжил харилцаа холбооны яамны бодлого, чиг үүрэг, "Алсын хараа 2050", "Цахим аймаг", "Цахим үндэстэн" бодлогын баримт бичгийн агуулга, салбар хоорондын ялдаа, цаашид хэрэгжүүлэх ажлыг танилцуулж нэгдсэн бодлого чиг үүргээр хангаж ажиллав.	
150	4.3.2. E-Mongolia хөтөлбөрийн	1. Төрийн үйлчилгээний	2021 -		124 2000	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийг эрчимжүүлэх цахим үндэстэн болох, Төрийн үйлчилгээг	

	хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна.	чанар хүртээмжийг сайжруулж, цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх	2024			цахимжуулах, хүн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх, зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 13-ний өдөр Баянхонгор аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, “ХУРДАН” цэгийг шинээр нээв.Тус хэлтэс нь Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байрлан үйлчилгээгээ үзүүлж байна. Мөн төрийн үйлчилгээг иргэдэд улам ортуулах зорилгоор “ХУРДАН” явуулын цэгийг санаачлан ажиллаж байна.	
151	4.3.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.	1. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах	2022 - 2024		40	Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн А/272 дугаар захирамжийн дагуу "Дижитал Баянхонгор" арга хэмжээ зохион байгууллаа. "Цахим шилжилтийг хүн бүрд" уриатай "Inspire 2022" арга хэмжээгээр 400 гаруй иргэд төрийн албан хаагч, 800 гаруй ЕБС-ын ахлах ангийн сурагчдыг хамарсан мэдээллийн технологийн чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан бол төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан 40 ажилтан мэргэжилтнүүдэд "Сүпер Админ" нэртэй Active director, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал сэвдийн хүрээнд 16 цагийн чадавхжуулах (24.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий) сургалтыг үнэ төлбөргүй зохион байгууллаа.Мөн УИХ-ын тамгын газар, цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи, ХХЗХ, зэрэг яам агентлагуудтай хамран төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдэд мэдээлэл өгөх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, шинээр хэрэгжиж байгаа цахим хөгжлийн багц хуулиудыг танилцуулах, төрийн цахим үйлчилгээний нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж нийт 5000-гаруй иргэд төрийн албан хаагчдыг хамруулан ажиллалаа.Аймгийн хэмжээнд нийт 59134 иргэн тоон гарын үсэг авахаас 2022 оны хагас жилээр 5360 буюу 9,6 хувь байсан бол жилийн эцсийн байдлаар 20222 буюу 34,1 хувь болж хагас жилээс 24,5 хувиа өссөн дүнтэй байгаа нь	

						иргэдийн цахим ур чадвар нэмэгдэж төрийн үйлчилгээг шуурхай авах боломж бүрдсэн	
152		2. Бүх төрлийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах	2022 - 2024		90 50	"Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг "Анар системс" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2022/158 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр бүрэн хүлээн авсан. Тус системийн ашиглалт хэвийн үргэлжилж байгаа бөгөөд, салбар бүрийн судалгаа, өргөөл гомдол, санал хүсэлт илгээх системийг салбар бүрээр нь ангилж QR код болгон ашиглаж байна, тайлан мэдээг сар, улирлаар гарган ажиллаж байна	
153		3. "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлтийг хийх	2022 - 2024		70	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем нь 8 модул системтэй бөгөөд 2023 оын байдлаар 3 модул бүрэн ашиглагдаж байгаа бөгөөд шинээр "Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг "Анар системс" ХХК хөгжүүлэлт хийсэн. Мөн тус компани нь "Албан бичиг төлөвлөлтийн систем"-ыг хөгжүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байгаа ДАШБОАРД буюу "Аймгийн тоон мэдээллийн нэгдсэн систем"-ийг батлагдсан төсөв нь тус програм хангамжийн хөгжүүлэлтэд хүрэлцэхгүй учраас энэ онд хэрэгжихгүй. Систем хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж дууссан.	
154	4.3.4. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.	1. Виртуал аялал хийх боломжтой "VR-Bayankhongor" төвийг байгуулж, контентийг нэмэгдүүлэх	2022 - 2024		600	Виртуал Баянхонгор төвийг орон нутгийн төсвөөр 250.0 сая төгрөгөөр байгуулсан бөгөөд үйл ажиллагааг эхлүүлж хувийн хэвшилд шилжүүлэн өгөхөөр Орон нутгийн өмчийн газраас дуудлага худалдааг 2 удаа зарлаж Айети Юнипикэшн ХХК 8 жилийн хугацаатай эргэн төлөх нөхцөлтэйгөөр хувьчлан авсан.	
155		2. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний	2021 - 2023		100	Тус арга хэмжээнд зарцуулахаар баталсан төсөвт өртөг ажлын даалгаврын дагуу систем хөгжүүлэлтэд хүрэлцэхгүй болсон тул тус ажил хэрэгжих боломжгүй болсон. Ажлын даалгавар болон техникийн нөхцөл бүрэн боловсруулж дууссан төсвийг дахин	

		газар, зам, хорооллыг заасан 360, VR, зураг, дүрсний танилцуулгыг хөгжүүлж Google street-д байршуулах				боловсруулж дараа жилийн төсөвт суулган хэрэгжүүлэх шаардлагатай.	
156	4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах	2021 - 2024		2 72 48	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 6 зорилт, 25 арга хэмжээ тусган, аймгийн Засаг даргын 2023 оны А/48 дүгээр захирамжаар баталж, орон нутгийн төсвөөс 8.000.000 төгрөг шийдвэрлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор цахимаар болон танхимын сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллагын дарга, удирдлага, төсөв санхүү хариуцсан мэргэжилтэн, бүх сумдын албан хаагчид болон хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт давхардсан тоогоор 1000 албан хаагчдад зохион байгуулсан. Сум, байгууллагуудын цахим хөгжүүлэлт хариуцсан 90 албан хаагчдад сургалт зохион байгуулан, цаашид цахим хуудсаа хэрхэн хөгжүүлж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 64 зурган мэдээллийг байршуулан 3000 иргэний гаруй хандалтыг авсан байна.	
157	4.4.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан	1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог шалтгаан	2021 - 2024		124 , 1721	Зөв амьдрал аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/33 дугаар захирамжаар батлан, орон нутгийн төсвөөс 5.000.000 сая төгрөгийг төсөвлөн, биелэлт 60 хувтай байна. Согтууруулах ундааны	

	нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна.	бууруулах				эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, холбогдох журмаар 50 худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт сургалт зохион байгуулан ажиллалаа. мөн БУСДЫГ СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭРЭГЛЭХИЙГ ШААРДАХ НЬ ХУУЛИАР ХОРИГЛОСОН ҮЙЛДЭЛ ШҮҮ ! ! "БИ Ч НЭГДЭНЭ, ТА Ч БАС НЭГД" challenge-ийг өрнүүлж 16 байгууллагын 400 гаруй алба хаагчдыг хамруулан зохион байгууллаа. мөн урьдчилан сэргийлэх масс мессэжийг юнителийн 3000 хэрэглэгчдэд хүргэн ажилласан. "Жаргалтай амьдрал төв"-ийг төвд архинд донтох өвчтэй 41 иргэн хэвтэн эмчлүүлснээс 39 иргэн нь эдгэрэлтэй байна.	
158		2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	2021 - 2024		41 , 153	-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Загс даргын 2023 оны А/ дугаар захирамжаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Баянхонгор аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, ГХУСАЗСЗ-тэй хамтран зохион "Амар тайван гэр бүл" нэгдсэн арга хэмжээний 20 сумын иргэд, ЕБС-н сурагчдад гэмт хэрэг зөрчлийн талаар мэдлэг олгох, эцэг эхийн зөвлөл, хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийн гишүүдийг мэргэшүүлэх өртөөчилсэн сургалтыг зохион байгуулж 2890 иргэн хамрагдсан. тус арга хэмжээний хүрээнд 500 ширхэг зурагт хуудас тарааж ажилласан.	
159		3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоог бууруулах	2021 - 2024		21	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн 3, хэсэгчилсэн 5 арга хэмжээг зохион байгуулж, олон нийтэд энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Тухайлбал: ерөнхий боловсролын 5 сургууль, 16 цэцэрлэгийн нийгмийн ажилтан, эцэг эхчүүдийн групп чатанд "Тото Лулу хоёр замын хөдөлгөөний дүрэмтэй танилцсан нь" цуврал 10 контент, "Хүүхдийн аюулгүй тээвэрлэлт" 1 контент, "Хүүхдийн суудал" CAR SEAT-ыг аюулгүй	

					зөв хэрэглэх заавар 1 контентыг тус тус байршуулж сурталчлан ажилласан. үүний үр дүнд гэмт хэргийн гаралт 9 бүртгэгдэж өмнөх онтой харьцуулахад ижил төвшинд байна.	
160	4. Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах	2021 - 2024		63	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн санаачилга, малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Шилдэг Малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж тус арга хэмжээнд ГХУСАЗСЗ-ийн зардлаас 3.000.000 төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллаж байна. мөн Богд, Жаргалант, Баацагаан, Жаргалант сумдын малчдын зөвлөгөөн болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, 2 төрлийн гарын авлага 1 төрлийн зурагт хуудас түгээж ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг илрүүлэх, мэдээ, мэдээлэл шалгах чиглэлээр Баацагаан, Галуут, Бөмбөгөр, Гурванбулаг, Баянбулаг сумдын нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж 6 бүлгийн нийт 14 этгээдийг баривчлан холбогдох ажиллагааг хийхэд гэмт этгээдүүд 8 удаагийн үйлдлээр иргэдийн 17 тооны адуу 10 тооны үхэр, 30 тооны бог малыг хулгайлан хээр малын бэлчээрт шөнийн цагаар нядлан толгой, арьс шириийг нь нүхэнд булж махыг нь худалдан борлуулж амар хялбар аргаар мөнгө олсон үйлдлүүд тогтоогдож, нийт 37,900,000 төгрөгийн хохиролтой гэмт үйлдлийг цагдаагийн газрын гомдол мэдээлэлд оруулан мөрдөн шалгах ажиллагаа явуулж 17 тооны адууг хохирогч нарт хүлээлгэн өгч 4 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, хэрэг бүртгэлтийн 5 хэргийг яллагдагчаар татаж ажилласан. Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 2023 оны 5 дугаар сарын байдлаар 19 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 нэгжээр буюу 27 хувиар буурсан үзүүлэлтэй байна.	
161	5. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд	2021 - 2024		58	Баянхонгор сумын гудамж, талбайн эвдрэл гэмтэлтэй теле хяналтын камеруудад үзлэг шалгалт хийж, 2 хяналтын цэг, 7 хяналтын камер ажиллахгүй байгааг засвар үйлчилгээ хийх, 3	

		дэмжлэг үзүүлэх				цэгийн хяналтын камеруудыг шинэчлэх, 500 метр шилэн кабель татах ажилд аймгийн төсөвт 10.0 сая төгрөг шийдвэрлэсэн. Аймгийн засаг даргын А/173 тоот захирамжаар замын цагдаагийн тасгийн алба хаагч нарын бэлэн бусын торгуулийн 18 багажын сунгалтыг 1 жилээр хийж хэвийн ажиллагааг хангасан. Өлзийт, Бууцагаан сумдын замын цагдаагийн байнгын постны дундаж хурдны хяналтын камерт үзлэг хийж интернетын төлбөрийг төлж хэвийн ажиллагаанд оруулсан.	
162		7. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх	2021 - 2024		50	2021 онд Баянхонгор аймгийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг танилцуулсан "Аймгийн хөгжлийн зөвлөгөөн"-д Баянхонгор сумын Хяналтийн камерийн ухаалаг системийн төслийн дагуу 2022 онд Баянхонгор сумд 190.0 сая, Бөмбөгөр сумд 40 сая, Галуут сумд 40 сая, Жинст сумд 40 сая төгрөгийн өртөг бүхий хаяналтийн камерийн системийн ажил хийгдэж байна. тус ажлуудаар Баянхонгор аймгийн хэмжээнд 63 ширхэг өдөр шөнө өнгөтөөр харах камер, 19 ширхэг хөдөлгөөнт камер, 4 ширхэг дугаар илрүүлэгчтэй камер суурилуулагдах ажил 95 хувьтай үргэлжилж байна.	
163	4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ.	1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх	2021 - 2024		1600	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар батлан, 50 хувьтай хэрэгжиж байна. Аймгийн хэмжээнд эрх зүйн хөтчөөр бэлтгэгдэн идэвхтэй ажиллаж байгаа 167 албан хаагчийг давтан сургах ажлыг дотоод нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулж, 90 гаруй эрх зүйн хөтчийг хамруулж, шинээр батлагдсан хуулийн тогтоомжийн эмхтгэлээр хангаж ажилласан. Дараагийн сургалтыг 9 сард хийхээр төлөвлөж байна. Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 25 байгууллагын 8200 гаруй иргэд, албан хаагч, сурагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, захиалгат танхимын сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажиллалаа. Хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг 350 гаруй иргэд, төрийн албан хаагчдад өгч, хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутгийн	

						телевиз, аймгийн www.bayankhongor.gov.mn цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар тогтмол сурталчлан ажиллаж байна.	
164	4.6.1. Албан хэрэг	1. Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээнд тоон гарын үсгийг бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.	2021 - 2024		60	Архивын лавлагаа мэдээллийг www.e-archives.gov.mn системээс онлайнаар бусад аймаг, хотоос Хөдөлмөр эрхлэлтийн 83, Цалингийн баримтын 14, Мал тооллогын 11, бусад төрлийн 1 буюу нийт 110 иргэнээс лавлагаа мэдээлэл үзүүлэх хүсэлт захиалга хүлээн авч, сан хөмрөгөөс хайлт хийн шийдвэрлэж, тоон гарын үсгээр олгох ажлыг үохион байгуулан ажиллаж байна.	
165	хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын	2. Төрийн болон байгууллагын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах.	2021 - 2023		70 , 0	Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 13 хөмрөгийн 781 хадгаламжийн нэгжийн 49286 хуудас, бүрдүүлэлтээр хүлээн авсан сан үүсгэгч 170 байгууллагын үндсэн 2020, нэмэлт 2009-2019 онуудын 14121 хадгаламжийн нэгжийн 209415 хуудас цаасан баримтыг хамгаалах хайрцагт шилжүүлж хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллаж байна.	
166	хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна.	3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх.	2021 - 2024		86	1.Төрийн архивын цахимжуулалт “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын цахим сангийн ажилтнууд сан хөмрөгт хадгалагдаж байгаа 13 хөмрөгийн 781 хадгаламжийн нэгжийн 49286 хуудас баримтыг цахим системд бүрэн шилжүүлж, 214849 өгөгдлийг оруулж баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлж, лавлагаа мэдээллийг онлайнаар үзэх боломжийг бүрдүүллээ. 2.Байгууллагуудын архивын цахимжуулалт Төрийн болон төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын сан үүсгэгч 170 байгууллагын үндсэн 2020, нэмэлт 2009-2019 онуудын 14121 хадгаламжийн нэгжийн 209415 хуудас цаасан баримтыг 04 дүгээр сарын 03-наас 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд хүлээн авч, цахим санд шилжүүлж ажилласнаар баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлж, онлайнаар хайлт хийх боломжийг бүрдүүллээ. Энэ үйл	

						ажиллагаанд нийт 290 албан хаагч, ажилтнууд ажиллалаа.	
167		4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах.	2021 - 2024		0,22	Архивын үнэ цэнэтэй, насжилт өндөртэй, муудаж урагдсан цаастай 27 хадгаламжийн нэгж баримтад цахим, нөөц хувь бий болгох, ашиглалтаас чөлөөлөх, мөн 1159 хуудас баримтыг сэлбэн засах, баримтын насжилтыг уртасгах арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.	
5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
168		2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод тарих	2021 - 2024		50000,50	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд 2023 оны хаврын мод тарих арга хэмжээнд нийт 20 сумын 392 айл өрх, 5828 иргэн, 253 ААН, байгууллага оролцож 48 га талбайд 16 төрлийн 48255 ширхэг тарьц, 4 төрлийн 78000 ширхэг харандаан суулгац тарьж, нийт 122,655 ширхэг тарьц, суулгац тарьж усалгаа арчилгааг хийж байна.	
169	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.	3. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах	2021 - 2024		20	Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг ШУТИС-ийн Ой модны сургалт судалгааны хүрээлэн боловсруулж дууссан. Тус төлөвлөгөөг БОАЖЯ, Ойн газарт хөндлөнгийн хяналт хийлгэхээр хүргүүлсэн.	
170		4. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх	2021 - 2024		30	Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг 5 дугаар сард зохион байгуулж аймгийн нийт нутгийн 80-90 хувьд хур тунадас нэмэгдүүлсэн. Эдийн засгийн үр ашгийн тооцвол аймгийн нутгаар нэмэгдүүлсэн хур тунадасны үнэ 161,710,000 төгрөгт хүрсэн. Мөн Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Хүрээмарал, Шинэжинст, Баянбулаг, Баян-Өндөр, Гурванбулаг сумдын нутгаар 5 дугаар сард олон жилийн дунджаас 4.1-25.3 миллиметрээр их хур тунадас орсон.	

171	5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах	1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах	2021 - 2024		3	Аймгийн хэмжээнд 861 булаг шанд тоологдсоноос 2006-2022 он хүртэл нийт 111 гол, булаг шандыг хашиж хамгаалсан байна. Үүнээс 107 булаг шандын эхийг хамгаалахад 459,115,300 төгрөг зарцуулсан, 4 булгийн эх хамгаалахад зарцуулагдсан төсөв тодорхойгүй байна. Хашиж хамгаалсан булаг шандаас эвдэрсэн 33, тоногдсон 14, сэргээн засварласан 4, хашилт хамгаалалтай байгаа 47 булаг байна. Цаашид 64 булгийн эхийг хамгаалах шаардлагатай байна. Энэ онд Бууцагаан, Галуут, Бөмбөгөр сум тус бүр 1 булгийн эхийг хамгаалахаар орон нутгийн төсөвт тусгасан ба бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн “Монголын унаган байгалийг тогтворжилтийг хангах нь” төслийн санхүүжилтээр Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан сумдад тус 1 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил зохион байгуулагдаж байна.	
172	хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах	2021 - 2024		150	Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор сургалт, сурталчилгаа, нөлөөллийн олон талт ажлыг аймгийн хэмжээнд тогтмол зохион байгуулсан. Нийтийн эзэмшлийн зам, талбай, гудамжийн хур хог хаягдлыг багасгах, орчны бохирдлыг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин бүрдүүлэх тухай" 02 албан даалгаврыг гаргасан. Тус албан даалгаврын хүрээнд сум тус бүр сард 1 удаа бүх нийтийн хог цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Бүх нийтээр мод тарих ажлын хаврын тарилтын хүрээнд нийт 122,655 ширхэг тарьц, суулгац тарьж усалгаа арчилгааг хийж байна. Мөн сумын малчид, байгаль орчныг хамгаалах нөхөрлөлүүдтэй хамтран 13 сумын нутаг дэвсгэрт зэрлэг амьтдын байршил бүхий газруудад идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлж 30 удаагийн давтамжтай өвс 1183 боодол, хужир 17.05 тонн, хорголжин 40 шуудай байршуулж биотехникийн арга хэмжээ авсан. Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа сумдын малчид, иргэдийн тусламжтайгаар усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн	

						бүсийн дэглэмийг тогтоох ажлыг зохион байгуулж байна.	
173	5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна.	1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	2021 - 2024		3	Аймгийн хэмжээнд 2023.01.01- 2023.05.01-нийг хүртэл хугацаанд Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт, Баянбулаг, Жаргалант, Галуут, Бууцагаан, Гурванбулаг, Заг, Жинст, Хүрээмарал, Богд, Шинэжинст зэрэг нийт 13 сумын нутаг дэвсгэрийг хамруулан зэрлэг амьтдын байршил бүхий газруудад идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлж 30 удаагийн давтамжтай өвс 1183 боодол, хужир 17.05 тонн, хорголжин 40 шуудай байршуулж биотехникийн арга хэмжээ авсан. Биотехникийн арга хэмжээ авах үед 453 орчим Янгир ямаа, 60 орчим Аргаль угалз, Буга, согоо-54 тоо толгой нүдээр үзэж тоолсон.	
174	5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.	1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2021 - 2024		70	1.Хүн амын ундны усны нөөц тогтоолгох шаардлагатай 10 сумаас “Сумын төвийн шинэчлэл” төсөлд хамрагдаж буй Өлзийт, Баацагаан сумдын усны нөөц тогтоолгох саналыг аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 1а/440 дугаартай албан бичгээр Барилга хот, байгуулалтын яаманд, 1а/441 дугаартай албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тус тус хүргүүлсэн. 2.Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн эрүүл ахуй, хими нян судлалын лабораторид сумдын 42 ундны усны эх үүсвэр шинжилгээнд хамрагдсан. Мөн Түйн гол, Байдраг гол, Дунд булаг, Оготнотой булгуудад Palintest Photometer 7100 багажийг ашиглан усны чанарыг 14 үзүүлэлтээр тодорхойллоо. 3.Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн А/72 дугаар захирамжаар аймгийн нутаг дэвсгэрийн усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн ба хязгаарлалтын бүсийг тогтоож, зурагжуулах ажлыг зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдад 2023 оны 05 дугаар сарын 09-25-ны хүртэл хугацаанд ажиллаж ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 47 талбай байгаагаас ашиглалтын 22, хайгуул 10 нийт 32 талбайг газар дээр нь очиж усан сан бүхий газрын	

						хамгаалалтын бүсийг тогтоож, тодотгол хийн зурагласан. Мөн Усны тоо бүртгэлд тоологдоогүй 108 булаг шанд, 18 гол, горхи, 6 нуурын мэдээллийг тодруулан, зурагжуулж усны мэдээллийн санд оруулаад байна.	
175	5.3.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	1. Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021 - 2024		50	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02-р сарын 28-ны өдрийн 02 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02 дугаар албан даалгаврын хүрээнд орчны бохирдлыг бууруулах зорилгоор бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, усны сан бүхий газрын 262 га, нийтийн эдэлбэр орчны бүсийн 2,494.4 га талбайн 292 тн хаягдлыг 150 орчим төрийн болон аж ахуй нэгж байгууллага оролцон 2803 орчим хүн оролцон төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн. Баянхонгор сум 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хог хаягдлыг эх үүсвэр дээл нь ангилан ялгах тогтолцоог эхлүүлж үнс-820 тн, хуванцар сав-1820 кг, бусад хог хаягдал төвлөрсөн хогийн цэгт 1627 тн нийт-4267 тн хог хаягдлын ангилсан байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг блокийн үйлдвэрт ангилсан үнсийг нийлүүлэлт хийж байгаа. "Цэвэр хот" ОНӨААТҮГ-аар хуванцар, шил, кардон цаасыг ангилан өөрийн эзэмшлийн хашаандаа бөөгнүүлэн пресслэх ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
176	5.3.2. Баянхонгор сумын гэр хорооллыг цэвэр усны болон дулааны шугамд шат дараатайгаар холбоно.	1. Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох	2022 - 2024		60	Залуус амины орон сууцны хорооллын гадна шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний(2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг) ажлын зургийг иж бүрнээр нь "ДНТ" ХХК-аар 2022 онд гүйцэтгүүлсэн. Уг зургийн дагуу инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэх тендер сонгон шалгаруулалтаар "Би Софт" ХХК шалгарсан. Өмнөх онд 2,3,6,7,9-р багуудад дулаан хангамжийн 1690м, бохир усны 1470м, цэвэр усны 2200м шугам хоолойн угсралтын ажил хийгдээд байна. Энэ онд 4,5-р багийн инженерийн шугам сүлжээний бохирын 740м, цэврийн 240 м ажил хийгдэхээр төлөвлөсөн. Эхний хагас жилийн байдлаар 5 р багт 240 м бохирын	

						шугамын ажил хийгдсэн.	
--	--	--	--	--	--	------------------------	--